

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3 - 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 - 45

1. <i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	5 - 8
2. <i>“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	8 - 45

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 03-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн;
Чөлөөтэй: Б.Жавхлан, С.Чинзориг, Б.Энхбаяр;*

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар санал хэлэв.

Ц.Цэрэнпунцаг: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ж.Ганбаатар, М.Оюунчимэг, Т.Энхтүвшин, О.Цогтгэрэл, Ч.Ундрэм, Б.Батгөмөр, Ц.Цэрэнпунцаг нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар үг хэлэв.

Ц.Цэрэнпунцаг: “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 02 минут үргэлжилж, 18 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 18 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Ингээд намрын чуулганы анхны Байнгын хорооны хурал эхэлж байгаа.

Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгаж байна. Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Хоёр гишүүн гадаад томилолттой. Орон нутагт нэг нь томилолттой, нэг нь гадаад томилолттой байна. Ж.Бат-Эрдэнэ гишүүн гадаад томилолттой ажиллаж байгаа. Ц.Даваасүрэн гишүүн орон нутагт ажиллаж байгаа юм байна.

Ингээд бусад гишүүд ирж, хуралдааны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

2023 оны 10 дугаар сард байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлбэ.

Та бүхэндээ тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт заасны дагуу “2023 оны 10 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёр. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Монголбанкнаас 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн. Хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудалдаа орёё.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор өөр саналтай гишүүд байна уу? Хэн байна? Та өргөсөн үү, үгүй юу? М.Оюунчимэг гишүүн. Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орёё.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай чуулганы 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь

хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 148 дугаар захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2.Хуульд хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-г үүрэг болгосугай.

Төсөлтэй холбоотой асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Уучлаарай. Ч.Хүрэлбаатар сайд та асуултаа асууя.

Ч.Хүрэлбаатар: Энэ Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн мэдүүлсэн байгаа.

Тэгэхээр Хөрөнгө оруулалтын тухай хуулийг энэ 10 дугаар сардаа хэлэлцээд шийдвэрлэхимээр байна.

Монгол Улсад эдийн засгийг хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд хөрөнгө оруулалтыг зайлшгүй татах шаардлагатай байгаа.

Тэгээд өчигдөр бүлгийн хурал дээр ч Ерөнхий сайд хэлсэн. Энэ Газрын тухай хууль, Улаанбаатар хотын газар олголт, саяын үертэй холбоотойгоор “Авлига хороолол”, тэр “S-Outlet” гээд газрын хуулийг нийтэд нь завхруулаад хүмүүсийн эрх ашигт хөтлөгдөж энэ Газрын хуулийг хөндөхгүй буюу үүнийг хамгаалах ийм чиглэл рүү ормооргүй байх юм.

Тэгээд Засгийн газар Газрын тухай хуулийг багцад нь энэ хуульдаа өөрчлөлт оруулъя гэж шийдэж байгаа юм.

Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулалт дээр байгаа тэр Газрын тухай хуулийнх нь хэсгийг нь татаж аваад, үлдсэнээр нь энэ Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг 10 дугаар сард хэлэлцэж явуулмаар байна.

Тэгэхгүй бол одоо юу болоод байна вэ гэвэл ингээд попорсоор байтал энэ улс орны эдийн засаг чинь бас хэцүү болж байна шүү дээ. Хэцүү шүү дээ.

Тэгэхээр эдийн засгаа тэлэх, эдийн засгийнхаа суурийг нэмэгдүүлэхийн тулд 10 дугаар сард бид Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг хэлэлцэхээр оруулж өгөхийг би санал гаргаж байна.

Тэгээд Засгийн газраас тэр Газрын хуультай холбоотой зүйлийг нь татаад авчихна. Тэгээд үлдсэнээр нь явуулъя гэж байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Энэ чинь яах вэ дээ, тэгээд нэг жижиг газартай холбоотой асуудал. Нэг зүйл, заалт дээр нь нэг ийм асуудал байна гээд л энэ асуудал чинь хойшилчихсон юм шүү дээ.

Та татаж аваагүй байгаа. Тийм ээ..? Та авчхаад буцаагаад тэр газартай холбоотой тэр хэсэг, зүйлээ хасаад оруулаад ирье гэж байгаа санал байна. Тийм ээ.

Тэгэхээр ингэе. Их Хурлын даргын 148 дугаар захирамж дээр энэ жагсаалт гаргасан байгаа. Энэ дээр ороогүй байна.

Тийм учраас даргын дэргэдэх зөвлөл дээр тав дахь өдөр би санал гаргаад оруулж ирчхээд тэгээд дараагийн. Даргын дэргэдэх зөвлөл тав дахь өдөр хуралдана шүү дээ. Энэ дээр. Аан..? Татчихсан байж бай, та. Тэгээд буцаад.

Тэгье дээ. Ийм санал байна. Эрхэм гишүүд ээ. Ч.Хүрэлбаатар сайдын гол санаа зовж байгаа, ярьж байгаа асуудал энэ цаг хугацаа. Бид 10 сард амжчихъя. Ялангуяа бид энэ хуулиа гаргаж, гадаадын хөрөнгө оруулагчдад бас мессеж, сигнал өгөх ёстой гэж тайлбарлаж байгааг дэмжиж байгаа юм.

Тийм учраас энэ хууль бол бүхэлдээ дотор нь байгаа ганц нэг зүйл, заалтаас болоод ингээд хойшлоод байх бол бас учир дутагдалтай байна.

Тийм учраас цөмөөрөө Ч.Хүрэлбаатар сайдын гаргасан саналаар цаглавар дотроо оруулчихъя. Байнгын хорооны цаглавараа батлах.

Тэгээд би тав дахь өдөр даргын дэргэдэх зөвлөлөөр санал оруулаад тэгээд энэ санал маань дэмжигдээд гараад ирвэл энэ чигээрээ явчихъя.

Гарч ирэхгүй бол цаглавараасаа энэ Хөрөнгө оруулалтынхаа хуулийг хасчихъя гэж тохироод үүнийг оруулъя гэдэг дээр санал хураалт явуулчихъя.

Та тэгээд санал гаргачих уу? Санал гаргачихсан гэж үзээд санал хураалгачихъя. Тэгэх үү?

Ингэе. Одоо үүнийг оруулахгүйгээр баталчхаад, дараа нь тав дахь өдөр оруулчхаад тэгээд цаглавар дээр нэмээд оруулчхаж болно гээд байна.

Манай зөвлөх өмнөх асуудалтай холбоотой энэ дээр бас нэлээн асуудал гарсан учраас ер нь цаглавараа бидний сая танилцуулсан энэ хавсралт байгаа. Тийм ээ.

Энэ цаглавараа баталж явчхаад, тэгээд энэ Хөрөнгө оруулалтынхаа хуулийг хэлэлцэх эсэхийг нь даргын дэргэдэх зөвлөл дээр шийдээд, дэмжигдээд ороод ирэхээр зэрэг цаглавар дээрээ нэмээд оруулчихъя. Ингэж тохирьё.

Та бүхэнд цаглавар тараасан байгаа. Энэ цаглавар дээр өөр санал гараагүй учраас ингээд үүгээрээ баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Би уншаад танилцуулчихъя. Томьёоллоо.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 10 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 81.8 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 10 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар

батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Ингээд дараагийнхаа асуудалд оръё.

Хоёр. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Монголбанк 2023.09.25-ны өдөр ирүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудал хоёр. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэж эхэлье.

Монголбанкныхныг оруулаарай.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийг Монголбанкны ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн танилцуулна.

Ингээд Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн микрофоныг нээе. Ажлын хэсэг 3 номер.

Б.Лхагвасүрэн: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилъе.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьж танилцуулж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикоос үүдэлтэй хүндрэлүүдийг Монгол Улс амжилттай даван туулж, эдийн засаг сүүлийн жил гаруй хугацаанд хурдацтай сэргэж байна.

Гэвч глобал эдийн эдийн засгийн орчны тодорхой бус байдал, гэнэтийн хэлбэлзэл өндөр хэвээр байгаа тул сэргэлтийг цаашид хадгалахын тулд эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг

хангахад чиглэсэн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай болно.

Эдийн засгийн өсөлтийн төлөв өндөр байгаа нь манай улс уналтаас сэргэлт рүү эрчтэй шилжиж байгааг илтгэж байна.

Гадаад орчны амаргүй нөхцөл байдал шууд болон шууд бусаар нөлөөлж байгаа хэдий ч эдийн засаг энэ оны эхний хагас жилд 6.4 хувиар өслөө.

Нүүрсний экспорт эрчимжиж, тээвэр, үйлчилгээний салбаруудын үйлдвэрлэл сайн байсан нь нийт өсөлтийг голлон тэтгэсэн болно.

Мөн төсөв мөнгө, санхүүгийн бодлогын арга хэмжээнд чухал нөлөөтэй байсныг бас энд онцлон дурдъя.

Эдийн засгийг энэ онд уул уурхайн салбар голлон тэтгэж, өсөлт 6 орчим хувь гарах, экспорт саадгүй үргэлжилбэл ирэх онд энэхүү өсөлтийн эрчийг хадгалах тооцоололтой байна.

Инфляцыг бага түвшинд бууруулах нь эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангахад суурь нөхцөл болох тул инфляцыг дунд хугацаанд 6 нэмэх, хасах хоёр нэгжийн хувийн интервалд тогтворжуулах мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Энэ нь Монгол Улсын эдийн засаг дунд хугацааны тогтвортой өсөх, хувийн секторын хэрэглээ, хөрөнгө оруулалтыг дэмжих үндсэн хөшүүрэг болно гэдгийг мөн онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Инфляц сүүлийн жил гаруй хугацаанд алгуур буурч, энэ оны 7 дугаар сард 9.2 хувь, 8 дугаар сард 10 хувьтай гарлаа.

Инфляцын эсрэг мөнгөний бодлогын төлөвийг чангаруулж, 2023 оны туршид бодлогын төлөвийг хадгалсны зэрэгцээ худалдааны түнш орнуудын инфляц саарч, тээвэр, логистикийн зардал болон хугацаа багассанаар гадаад шалтгаантай үнийн дарамт буурсан нь мөн нөлөөлсөн болно.

Хэдий инфляц энэ оны зорилтын түвшинд буурч ирсэн ч гадаад, дотоод эрсдэл, тодорхой бус байдал өндөр хэвээр байна.

Иймээс мөчлөг сөрсөн сахилга баттай төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлж нийлүүлэлтийн гинжин сүлжээ, ялангуяа дотоодын хүнсний тогтвортой тасралтгүй хангамжийг бий болгох, иргэд, үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчдын бодит орлогыг хамгаалсан нам тогтвортой түвшний инфляцад хүрэх боломж ихээхэн хязгаартай гэдгийг мөн онцлон дурдахыг хүсэж байна.

Цаашид Монголбанкны мөнгөний бодлогын хороо инфляц зорилтот түвшин тогтворжих хүртэл шаардлагатай мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Төлбөрийн тэнцлийн талаар Та бүхэнд товчхон танилцуулъя.

Энэ оны эхнээс экспортын эрч хадгалагдаж, манай улс валютын цэвэр орох урсгалтай байлаа.

Гадаад валютын албан нөөц 8 дугаар сарын эцсийн байдлаар 3.9 тэрбум доллар. Яг өнөөдрийн тоогоор 4.1 тэрбум долларт хүрсэн нь сүүлийн 20 сарын хамгийн дээд өндөр үзүүлэлт болж байна.

Экспорт сайн байгаа хэдий ч эрдэс бүтээгдэхүүний төлөв буурах хандлагатай байгаагийн зэрэгцээ төсвийн өндөр зардал импортыг өдөөж валютын гарах урсгалыг бий болгож байгаа нь төлбөрийн тэнцлийн нөхцөлийг бас муутгаж болзошгүй гэсэн ийм таамаглалтай байна.

Юуны түрүүнд улсын санхүүгийн нөөц чадавхыг хамгаалахад онцгойлон анхаарсан хатуу төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, аливаа хөгжлийн бодлогыг гадаад эх үүсвэрт тулгуурлан дотоодын санхүүгийн чадавхтай нийцүүлэн хэрэгжүүлэх ийм шаардлагатай байгаа болно.

Энэ жилээс Улсын Их Хурал жил бүрийн Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн баталдаг болсонтой холбоотойгоор энэ удаагийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг Монголбанк хуульд заасан өөрийн үндсэн зорилт, чиг үүргийн хүрээнд тодорхойлон боловсруулж ирлээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл нь инфляцыг тогтворжуулах замаар дунд хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, гадаадын банкны бие даасан салбар нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлж ажиллуулах, ногоон зээлийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх, хил

дамнасан худалдаа, цахим төлбөр, тооцоо болон финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийг дэмжих зэрэгт онцгойлон анхаарч боловсрууллаа.

Инфляцын зорилтыг хангахад эдийн засгийн суурь хүчин зүйлс, Төв банкны хараат бус байдал, төсвийн сахилга бат, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн хэлбэлзлийг багасгах, дэд бүтэц, логистикийн нөхцөл байдал ихээхэн нөлөөтэй.

Иймээс Монголбанк инфляцыг онилох мөнгөний бодлогыг тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь дэд бүтцийг бий болгохтой холбоотой зорилтыг энэ онд шинээр тусгалаа.

Банкны салбарт эх үүсвэрийн зардал багатай, урт хугацаатай хөрөнгө оруулалт, ногоон тогтвортой хөгжлийн төслийг санхүүжүүлэхэд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход гадаадын банкны бие даасан салбар нэгжийг дотоодын санхүүгийн салбарт оруулах нь томоохон нөлөө үзүүлнэ гэж харж байна.

Иймээс ирэх онд гадаадын банкны салбар нэгжийн үйл ажиллагааг явуулахад тавигдах нөхцөл, шаардлагыг гадаадын банкны харьяалал, өмчлөлийн төрөл, бизнес загвар зэрэгт нь тохируулан тогтоож, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг бий болгоход анхаарал хандуулж ажиллах болно.

Мөн ногоон хөгжлийн зорилтуудыг хангах, тогтвортой санхүүжилтийн замын зурагт зурагдсан банкны салбарын ногоон зээлийн багцыг 10 хувьд хүргэх зорилтыг хангахад ногоон зээлийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн

системийг цаг алдалгүй хөгжүүлэх шаардлагатай болно.

Энэ чиглэлээр Монголбанк дээр хөгжүүлж эхлээд байгаа “Их өгөгдөл”-ийн дэд бүтцийг ашиглан ногоон тогтвортой санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг шат дараатай бий болох ажлуудыг банкнуудтай хамтран ирэх оноос хөгжүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна.

Цаашид үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангахад макро эдийн засгийн бодлогуудыг чиглүүлэх нь чухал болж байна.

Монголбанкны 2024 оны бодлого, үйл ажиллагаа, инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд Та бүхнээс Төрийн мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгчид баярлалаа.

Танилцуулга 9-нд ингээд ажлын хэсгийг танилцуулъя.

Ажлын хэсэг. Бадрангийн Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Баярсайханы Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал, Атарбаатарын Энхжин Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал,

Дамдинжавын Даваасүх Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал.

Төсөлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Ч.Ундрам, Т.Доржханд гишүүн, Б.Батгөмөр гишүүнээр тасаллаа. Д.Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Надад хоёр, гурван асуулт байна. Өнгөрсөн жил Монголбанкныхан инфляцын түвшинг ямар хэмжээнд барих вэ гэдэг саналаа оруулж ирж байсан.

Энэ зорилт чинь хэрхэн биелсэн бэ? Учир шалтгааныг нь тайлбарлаж хэлж өгөөч.

Энэ инфляцын түвшингөө тухайн түвшинд барьж чадаагүйтэй холбоотой ямар асуудлууд байсан юм? Хүндрэл бэрхшээлүүд нь ямар байгаа юм? Энэ жилийн инфляцын түвшин гэж 6 дээр нэмэх, хасах 2 гээд төлөвлөөд байгаа зорилт чинь биелэх юм уу? Боломж нь байгаа юм уу гэдэг дээр нь хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь, төвлөрлийг бууруулах шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагтаа шилжин очиж байгаа иргэдэд ипотекийн зээлийг 3 хувийн хүүтэй олгоно гээд нэлээн ярьсан.

Яг үнэндээ орон нутагт ипотекийн зээл олгогдож байгаа газар алга байна. Яах вэ, манайд гэх юм бол уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн ажилтан, албан хаагч нарт Худалдаа, хөгжлийн банкныхан нэг тийм зээл олгож байх шиг байгаа юм.

Бусад аж ахуйн нэгжийн салбарт ажиллаж байгаа хүмүүст зээл олгож байгаа зүйл алга.

Тэгээд бид ингээд л яриад л байдаг, яриад л байдаг, аймаар гоё шийдвэрүүд гаргаад л байдаг. Яг газар дээрээ, хэрэг дээрээ ийм үл гүйцэтгэсэн байдалтай байх байгаад байгаа.

Тэгэхээр үүнийг бид хэзээ засаж залруулах юм бэ? Ийм байдлаараа цаашдаа яваад байх юм уу? Хэний хариуцлага юм бэ гэдэг дээр хариулт өгөөч.

Гуравдугаарт нь, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа энэ арилжааны банкнууд ер нь хэр ашигтай ажилладаг юм бол оо? Та тоон мэдээлэл байвал нэг хэлж өгөөч.

Яах вэ, ингээд урьд нь ч авч байсан мэдээллүүд дотор байсан. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкууд маш олон охин компаниудтай гэж байна. Тэр охин компаниудаараа дамжуулж төрөөс, гадаад болон дотоодоос хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд, маш бага хүүтэй зээлүүдийг асар ихээр авдаг.

Хэрвээ энэ бодитой мэдээлэл юм бол та яг ийм ийм банкнууд ингэж ингэж ажиллаж байгаа, ийм охин компаниуд байгаа, тийм хэмжээний зээл, тусламжид орсон, хамрагдсан гэдэг тоо баримтаа бид нарт танилцуулаач ээ.

Тэгээд энэ байдал нь өөрөө яг энэ тэр банкны системд байх ажил мөн юм уу? Байх ёстой зүйл мөн юм уу? Хэрвээ байхгүй байх ёстой, зөвхөн банк маань арилжааны хэлбэрийн үйл ажиллагаагаа л явуулах ёстой гэж үздэг бол Монголбанкнаас энэ дээр ямар арга хэмжээ авч байгаа юм? Энэ бол тийм нууц биш зүйл гэж харж байгаа.

Ер нь зүгээр захын хүмүүс бараг мэднэ. Тэгэхдээ би таны амнаас сонсмоор байна. Албан ёсоор. Энэ асуултууд дээр надад хариулт өгөөч ээ. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс. 3 номер хариулах юм байна.

Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө, Д.Батлут гишүүн гурван тодорхой асуулт асуусан.

Гурав дахь асуултад би бас тодруулаад. Миний ойлгосноор банкны хөрөнгө оруулагчид маань тэр банкандаа нөлөөлөөд бусдаас давуу эрх үүсгээд тэр зээлийг нь аваад байдаг юм уу гэсэн агуулгаар асууж байна гэж ойлгосон шүү.

Тэр дээр нь та яг тэр утгаар нь хариулбал зүгээр байх гэж бодож байна. 3 номерын микрофоныг нээе.

Б.Лхагвасүрэн: Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн оны сүүлээр энэ 2023 онд баримтлах төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг Их Хурлаас баталж өгсөн.

Их Хурлаас баталж өгсөн үндсэн чиглэлд энэ 2023 онд инфляцын түвшнийг нэг оронтой тоонд оруулахаар ийм заалт оруулсан байгаа.

Энэ заалтыг ч анх тухайн үедээ тэгж санал тавьж байсан. Учир нь КОВИД-ын хоёр жил, тэгээд 2022 он бол ерөнхийдөө олон улсын геополитикийн маш тийм хурцалмал нөхцөл байдлын жил.

Ер нь бүх улс орнуудад инфляц өөрөө нэгэнт олон улсын хэмжээний асуудал болсон гэдэг утгаараа Монголбанкны хувьд өмнө нь байсан тэр

6 нэмэх, хасах 2 хувь гэдэг нарийн онилсон бодлогоосоо арай илүү нэг оронтой тоо гэсэн ерөнхийдүү ийм зорилтыг санал болгоод ингээд батлуулж авсан.

Өнгөрсөн оноос хойш сүүлийн нэг жил гаруй хугацаанд инфляцын түвшин хамгийн өндөр түвшин 16 хувиасаа буураад явж байна. Сая 7 сард 9.2 хувьтай гарсан. 8 сард 10 хувьтай гараад ингээд явж байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө нэг оронтой тоо руугаа орох бүрэн магадлалтай явж байгаа учраас мөнгөний бодлого энэ оны хэрэгжилт хэрэгжиж чадна гэсэн Монголбанкны төсөөлөл, тооцооллолтой байгаа.

Тэгээд энэ оны сүүл рүү нэг оронтой тоо руугаа орчих байх гэсэн ийм тооцоолол байна.

Яах вэ, сая яагаад энэ 8 сард буцаад ингээд 10 болоод хоёр оронтой тоо руу орсон бэ гэхээр энэ 6 сард төсөв тодотгосон. Төсвийг тодотгоход 1.8 их наядаар нэмж зардлыг нэмсэн байгаа.

Тухайн үед төсвийг ингэж тодотголыг хэлэлцэж байх үед Засгийн газраас ч тэр, Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам өөрсдөө ерөнхийдөө энэ төсвийн тодотголоор инфляц хоёр нэгж хувиар өдөөгдөх магадлалтай гэсэн.

Бидний хувьд 8.5 хувь руу гэсэн төсөөлөл тухайн үед байсан бол энэ нь өөрөө ингээд хоёр нэгж хувиар нэмэгдээд 10.5 ч гэдэг юм уу. Энэ рүү орохоор.

Тэгэхээр 8 сарын 10 гэдэг энэ тоо бол яг тэр тооцоо, судалгаатай ерөнхий ерөнхийдөө нийцтэй гарч байгаа юм. Тэгэхдээ бидний хувьд энэ оны төгсгөлд нэг оронтой тоо руугаа ирэх боломжтой гэж харж байгаа юм.

Хоёр дахь асуудлын хувьд Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд “Шинэ Хөдөө” гээд Засгийн газрын бодлого хэрэгжиж байгаа. Ялангуяа энэ дотор хөдөө орон нутагт ард иргэдийг тийм тохилог орон сууцад амьдруулахаар тийм орон сууцууд нэлээн баригдаж байгаа. Түүнд нь энэ ипотекийн зээл олгоход, ялангуяа ипотекийн зээл нь өөрөө таны асууж байгаа тэр 6 хувийн ипотекийн зээлийн эхний 3 жилдээ 3 хувь болох, 3 хувийн хүүгийн дотаци нь улсын төсөвт суусан гэдгээрээ Улаанбаатар хотоос орон нутаг руу шилжиж байгаа болон орон нутагт амьдарч байгаа, тэгээд анх удаагаа ипотекийн зээлд хамрагдаж байгаа улсууд энэ хөтөлбөрт хамрагдах бүрэн боломжтой байгаа.

Дээр нь ипотекийн зээлийн журамд хэвээ урьдчилгаа төлбөрийн 30 хувиа төлж чадахгүй иргэд мөн Зээлийн батлан даалтын сангаас 60 хувиа батлан даалгаад буюу 100 саяын орон сууц авах гэж байгаа хүн 30 саяыг урьдчилж төлөхийн оронд 15 саяыг төлөөд, 15-ыг нь зээлийн батлан даалтын сангаар баталгааг нь гаргуулаад ингээд орон сууцад орохоор ийм хөнгөлөлттэй заалтууд нэлээн хэрэгжээд явж байгаа.

Яагаад сая энэ хөтөлбөр өөрөө ингээд зогссон бэ ч гэдэг юм уу, ингээд нэлээн удааширсан бэ гэдэг нь өнгөрсөн онд Монголбанк ипотекийнхоо хөтөлбөрийг Засгийн газарт эхний хагас жилдээ багтаагаад шилжүүлэхээр анх ажлын хэсэг байгуулаад ажиллаад эхэлсэн.

Тэгээд 7 сарын 01-н хүртэл эхний 6 сард нь асуудалгүй байхаар эх үүсвэр гараад явж байсан. Тэгээд нэгэнт Засгийн газартаа хагас жилд багтааж шилжүүл.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Хариулт 1 минут нэмж өгье.

Б.Лхагвасүрэн: Засгийн газарт шилжүүлж чадаагүй гэдэг утгаараа одоо эргэж ирж байгаа. Эргэн төлөлтийнхөө хэлбэрээр эргээд ингээд гараад явж байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө эргээд хэвийн байдалдаа орж байгаа гэж хэлж болно. Энэ 7 сарын 01-нээс хойш. Ялангуяа сая 9 сарын 01-нээс хойш банкнууд нэлээн идэвхтэй олгоод явж байгаа.

Би танд аль аль аймагт хэчнээн орон сууц ямар хэлбэрээр яасан бүх нарийн тоог мэдээллийг танд би тусад нь гаргаж өгье.

Гурав дахь асуултын хувьд Банкны тухай хуулиар банкууд доороо охин компанитай байхыг хориглочихсон байгаа.

Тэгэхээр банкных нь доор шууд банкны охин хараат компани байхаар компани байхгүй. Зүгээр банкны эздүүд буюу хөрөнгө оруулагч нар өөр өөрийн компанитай. Тэр нь янз янзын салбарт янз янзын компаниуд байгаа.

Олон улсын байгууллагууд сүүлийн үед арилжааны банкуудаар ийм хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээлийг нэлээн оруулж ирж байгаа. Ялангуяа энэ онд евро.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн нэмж асуух уу? Д.Батлут гишүүн нэмэлт асуулт асууя.

Д.Батлут: Хариулт маань байгаа онохгүй тойрсоор байтал хугацаа нь болчих юм. Тэгээд аягүй хэцүү юм.

Зээл олгож байгаа юм байна. Ипотекийн зээлийг. Тэгээд шалтгааныг надад тодруулж өгмөөр байгаа юм. Тэр 7 сараас хойш олгогдоогүй. Одоо 9 сараас хэвийн болж байна гээд байгаа юм. Ямар шалтгаантай юм бэ гээд. Тийм.

Тэгээд орон нутагт нэг ийм хязгаар тавьчихаад байгаа юм. 100 сая төгрөгөөс дээшээ орон сууц худалдаж авах боломжгүй болчихоод байгаа юм. Иргэд.

Гэтэл өнөөгийн үнэ цэн нь ямар байгаа вэ гэдгийг манай Монголбанкныхан ер нь мэдэж байгаа юу? Одоо манай Орхон аймаг бол харьцангуй бас зүгээр 2 өрөө байр гэхэд л бараг л. Зүгээр хуучны угсармал 2 өрөө байр гэхэд л 100 сая дөхөж байна шүү дээ. Тэгээд шинэ байр авахлаар 100-аас халиад л явчихна.

Тэгэхээр энэ дээрээ ямар зохицуулалтууд хийх юм бэ? Тэгээд л заавал нэг тийм байх ёстой гээд 100 саяараа хязгаарлаад л яваад байх юм уу?

Ц.Цэрэнпунцаг: 3 номер хариулья.

Б.Лхагвасүрэн: Энэ ипотекийн зээлийн журамд хөдөө орон нутагт 100 сая, Улаанбаатар хотод 150 сая гээд ийм хязгаартай, хоёр ялгавартай хязгаар байсан.

Тэгээд энэ долоо хоногт Монголбанк энэ журамдаа бас өөрчлөлт оруулаад энэ хязгаарыг арилгасан.

Тэгэхээр хот, хөдөө ялгаваргүйгээр дээд хязгаар нь 150 болсон байгаа юм.

Тэгэхээр таны асуулгаж байгаа энэ асуулт бол ерөнхийдөө журамдаа өөрчлөлт орчихсон.

Ц.Цэрэнпунцаг: Д.Батлут гишүүн ээ, та хариулт хангалтгүй гэж үзвэл дахиж нэмж асууж болно. Д.Батлут гишүүн хариулт хангалтгүй гэсэн учраас дахиад. Болчихсон уу? Сая авчихсан уу?

Н.Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Өнөөдөр ч маш чухал асуудал хэлэлцэж байна л даа.

Монгол Улсын эдийн засаг маань ер нь суурь тогтолцоо нь ер нь буруу байгаагийн илрэл нь өнөөдрийн бид бүхний энэ мөнгөний бодлого, төсвийн алдагдалтай өргөн барьж байгаа байдал. Хувийн хэвшлийнхэн иргэдийн амьдрал үнэхээр хүнд болж байна.

Хэдий цалин, тэтгэвэр нэмээд байгаа боловч бодит нөхцөл байдал дээр нөгөө худалдан авах чадвар нь өмнөхөөсөө дордоод байх юм.

Тэгэхээр энэ асуудлуудыг цогцоор нь авч хэлэлцэхгүй бол жил болгон мөнгөний бодлого, нүүрсний үнэ, зэсийн үнэ оруулж ирээд инфляцыг тэдэн хувьд оруулна гээд нэг тоотой. Тэр нь тэгээд жил болгон хэрэгжилт нь биелдэггүй.

Засгийн газар нь Монголбанкныхаа гаргасан зөвлөмжийг хэзээ ч хэрэгжүүлдэггүй нэг ийм л улс орон болчихлоо.

Хоёр хоногийн өмнө Засгийн газрын өргөн барьсан төсөв чинь хэдэн хувийн алдагдалтай төсөв вэ? 35 хувиар зардлаа нэмсэн. Тэгээд дотоодын нийт бүтээгдэхүүний 2.3 буюу 2.1 их наядын алдагдалтай ийм төсвийг өргөн барьчихлаа.

Өнөөдөр бид сайхан юм яриад Монголбанк маань эргээд сайн сайхныг яриад байх юм. Тэр Засгийн газартайгаа

төсвийн алдагдал, төсвийн тэлэлтийн асуудлаа ер нь уялдуулж чадаж байгаа юм уу?

Төсвийн зардал нэмэгдэх, тэлэх тохиолдолд нөгөө инфляц, валютын ханшны дарамт нэмэгддэг, мөнгөний бодлого сулардаг, орон зайгүй болдог.

Тэгээд Засгийн газрын өргөн барьсан энэ төсөв чинь та бүхний яриад байгаа энэ бүх юмыг чинь үгүйсгэж байна шүү дээ. Тэгээд ийм байдалтай одоо ингээд энд тэнд хэдүүлээ бие биедээ мэдээлэл өгөөд, бодлого нь нэгтгэгддэггүй, Монгол Улсын эдийн засгийн нэгдсэн бодлого байхгүй, мөнгөнийх нь бодлого нь Засгийн газрынхаа барьж байгаа тэр эдийн засгийн бодлого, төсвийн бодлоготойгоо уялддаггүй энэ асуудлуудаа бид ер нь цаашид яаж засах юм бэ?

Энэ дээр тэр төсвийн алдагдлын асуудал дээр та бүхэн бас яг ямар арга хэмжээ ав авах гэж байгаа талаараа бидэнд мэдээлэл өгөөч.

Дээрээс нь төсвийн алдагдал өнгөрсөн 7 жилд нийлээд 12 их наяд болсон гэсэн. Энэ жил 2.1-ээр нэмэгдэж байна. Ингээд алдагдалтай төсөв улам цаашаа яваад байдаг. Төсвийн зардлаа нэмээд байдаг. Энэ асуудал дээр та бүхэн ер нь ямар байр суурьтай байдаг юм?

Тэр нэг тонн нүүрсээ 140 доллароор ирэх жил зараад 60 сая тонныг экспортод гаргана гэсэн төсөөлөл оруулж ирсэн байна лээ. Орлого.

Тэгэхээр энэ боломж байна уу? Зэс дээр 9 мянган доллар гэсэн байна. Ханшийн асуудлыг бас сонсьё. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер.

Б.Лхагвасүрэн: Н.Ганибал гишүүний асуултад хариулъя.

Тийм. Ерөнхийдөө хэрвээ төсөв тэлэлттэй байх юм бол мөнгөний бодлого яаж хоршиж ч юм уу, нийцэж ажиллах вэ гэвэл эсрэгээрээ хатуу мөнгөний бодлого болно.

Тэгэхээр 2023 оны хувьд Монголбанкны мөнгөний бодлого маш хатуу явж ирсэн. Өнгөрсөн оны сүүлээр бодлогын хүү 13 хувьд буюу хамгийн дээд түвшинд хүрчихсэн явж байна. Үүнийгээ энэ оны туршдаа бид хэд ингээд хадгалаад явж байгаа.

Тэгэхээр 13 хувийн хүү гэдэг бол одоо ингээд зээлийн хүү дээр энэ суурь хүү болоод зээлийн хүүг нэмэгдүүлж байгаа. Тэгээд өнөөдөр банкны дундаж зээлийн хүү 18, 19 хувьтай байгаа.

Дундаж хүү нь 16 хувь боловч яг өнөөдөр арилжааны банкн дээр зээл авч байгаа улсууд энэ 18, 19 хувийг л санал болгож байгаа маягаар явж байна.

Тэгэхээр энэ утгаараа мөнгөний бодлого ингээд л хатуу чигээрээ л явна гэсэн үг.

Тэгэхээр ирэх онд төсөв дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувийнтай тэнцэх ийм алдагдалтай байгаа энэ тохиолдолд энэ алдагдлыг нөхөхийн тулд нэг бол дотоодынхоо заххаас хүү татаж авна.

Хэрвээ дотоодын заххаас хөрөнгө татаж авна гэдэг маань өөрөө эргээд тийм өндөр хүүтэй зардалтай л эх үүсвэр татна гэсэн үг. Эсвэл дотоодын заххаас авахгүй гэвэл гаднын заххаас авах болно. Гадаадад өнөөдөр бүх улсын инфляц бүх улсад өндөр. Ялангуяа Америкийн Нэгдсэн Улсын хүү 5 хувь гарчхаад явж байна.

Энэ утгаараа бас их өндөр зардалтай ийм эх үүсвэр л татагдана гэсэн үг.

Тэгээд энэ утгаараа зардал маш өндөр болно л гэж харж байгаа. Тэр утгаараа Монголбанкны хувьд инфляцыг тогтвортой түвшинд оруулахын тулд мөнгөнийхөө хатуу бодлогыг хэвээр нь хадгалахаас ийм өөр замгүй байгаа.

Ерөнхийдөө та түүрүүн бас энэ зэсийн үнэ, нүүрсний үнийн талаар асууж байна.

Яах вэ, Монголбанк ирэх оны төлбөрийн тэнцэл, Монгол Улсын экспорт импортын зөрүү ч гэдэг юм уу, Монгол Улсын валютын нөөцийг хэр хэмжээнд байх вэ гэдэг тооцоо судалгааг хийхдээ гадаад орчны нөхцөл байдлыг нэлээн сайн сайн шинжилдэг. Ялангуяа Монгол Улсаас манай түүхий эдийг худалдан авдаг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хувьд эдийн засгийн өсөлт нь нэлээн саарчихсан. Дээр нь олон улсын геополитикийн хурьцалдмал нөхцөл байдал бас тийм таатай биш байгаа учраас түүхий эдийн үнэ дээр бидний хувьд маш болгоомжтой байгаа.

Мөн экспортын тоо хэмжээн дээр ч гэсэн болгоомжтой байгаа. Тэр утгаараа бидний хувьд хийж байгаа манай төлбөрийн тэнцлийн төсөөлөл таны саяын хэлж байгаа тэр тоонуудаас арай даруухан гэдэг юм уу арай доогуур байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Энд уул уурхайн сайд нь байж байна. Зэс, нүүрсний экспорт ямар хэмжээтэй, ямар үнэтэй байх юм гэж. Яаж харж байгаа юм бол. Сайд товчхон нэмэлт хариулт өгчих үү?

Ж.Ганбаатар сайдын микрофоныг нээе дээ.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Уул уурхайн салбар 60 битгий хэл гаргах бүрэн бололцоотой.

Н.Ганибал гишүүн сайн мэдэж байгаа байх. Тийм ээ.

Яах вэ, ноднин бид чинь 36-гаар баталлуу даа. Тийм ээ. Чадна, чадахгүй гээд л.

Тэгээд одоо яах вэ, эхний 9 сарын байдлаар бараг 51 сая тоннд хүрчихсэн байгаа. Бид ер нь энэ хурдаараа явах юм бол энэ жилдээ бараг 57, 58 саяын тонн гаргах бүрэн бололцоотой байгаа. Энэ жил шүү дээ. Тийм ээ. 2023 ондоо. Одоо үлдэж байгаа 3 сардаа гэсэн үг шүү дээ. Нэмэгдүүлээд.

Ер нь долоо хоногт бараг 1.2 сая тонн нүүрс экспортолчихоод байгаа байх шүү.

Манайх чинь төрийн нүүрсээ л зөвхөн биржээрээ зарж байгаа шүү дээ. Тийм. Хууль нь ч гэсэн тэр. Төрийн компаниуд.

Тэгэхээр тэр төрийн компаниудын 30 хувь нь биржээр зарагдаж байгаа. Нийт нүүрсний гэдгийг манайхан буруу ойлгоод байх шиг байгаа юм. Нийт гэхээрээ нөгөө хувийн хэвшил чинь орчхоод байгаа шүү дээ.

Тэгээд “Эрдэнэс Тавантолгой” чинь ойролцоогоор 23, 24 сая тонн руу хүрч байна уу, одоо. Тэрний 30 хувийг бид биржээр зарчхаж байгаа шүү. 2024 ондоо 50, 2025 ондоо ингээд нэмэгдээд явна. Би гол асуултдаа орёе.

Гол саад та мэдэж байгаа. Тийм ээ. Тээвэр ложистик, хил гааль, худалдан авах улсын тэр квот гэдэг юм уу, дотоод асуудал, хэрэгцээ.

Тэгэхдээ яах вэ, худалдан авах улсын асуудлууд дээр Ерөнхий сайдын айлчлал, Ерөнхийлөгчийн айлчлалын нөлөөлөл их орсон. Нэлээн хэрэгцээ нь бас байгаа гэж бид харж байгаа. Манайх чинь эрчим хүчний нүүрс гэхээсээ илүү коксжсон нүүрс 95 хувь нь экспортолж байгаа.

Тэгэхээр манайхан нөгөө эрчим хүчний нүүрсний хэрэглээ багассан, эсвэл өрсөлдөгч гээд Австрали, Индонез гэдэг юм уу ингээд эрчим хүчний нүүрсний өрсөлдөгч нарыг их яриад байдаг. Коксжсон нүүрс мэдээж Австрали, Орос гээд улсууд байна л даа.

Тэгэхээр бид 60 сая тонныг гаргах бүрэн бололцоотой гэж харж байгаа.

Зэсийн хувьд 1.5 гэдэг бол ерөөсөө тогтсон тоо шүү дээ. Энэ бол нэг их нэмэгдээгүй. Харин ч 1.5-аас илүү зэсийн баяжмал гаргах бүрэн бололцоотой.

Энэ бараг 1.6, 1.7 руу бараг хүрэх байх шүү. Оюу Толгойн далд уурхай нэлээн нэмэгдэж байгаа. Н.Ганибал гишүүнд бас мэдээлэл байгаа байх.

140 доллар гэдэг бол харин дундаж үнэ. Өнөөдөр 182 доллар байгаа. Коксжсон нүүрсний биржийн арилжааны үнэ. Товчхон ингэж хариулья.

Ц.Цэрэнпунцаг: Товчхон тодорхой хариулт өгсөн. Та нэмж асуулт байна уу? Н.Ганибал гишүүн нэмэлт асуулт асууя.

Н.Ганибал: Тийм. Ер нь сайхан төсөөллүүд, сайхан мэдээллүүд байна л даа.

Тэгэхээр Монгол Улсын эдийн засгийг би хэлээд байна л даа. Зэс, нүүрс дээрээ төвлөрсөн. Тэрийг нь төрийн өмчийн компаниуд эзэмшдэг. Тэндээсээ

олж ирж байгаа орлогууд нь төсөв дээрээ төвлөрдөг. Төсвөө тэгэхдээ бас ингээд алдагдалтай, зарлага өндөртэй баталчихдаг.

Тэгээд тэр төсөв дээрээс нь яаж байна вэ гэхээрээ төсөв тойрсон хулгайнууд явчихсан. Ингээд энэ дээр нь нөгөө дарга, цэрэг ангийнхны хамгийн том хулгай, эрх баригчдын хулгай явдаг. Ногоон автобус өчигдөрхөн ингээд олон нийтэд ил болоод ингээд явж байна.

Ийм л эдийн засагтай Монгол болчихлоо. Энэ хулгайнаасаа яаж салах юм. Яаж энэ жижиг, дунд үйлдвэрлэлээ хөгжүүлэх юм. Тэр дундаж орлоготой иргэдээ сайжруулах юм. Бодит амьдрал дээр иргэд дээр энэ мөнгөний зөв бодлого чинь очихгүй байна. Энэ нүүрс, зэсийн өндөр үнэ чинь очихгүй байна.

Тийм учраас энэ дээр Засгийн газар, Монголбанк хоёр энэ дээр нэгдсэн зөв эдийн засгийн тогтолцоогоо бас.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Н.Ганибал гишүүн ерөнхийдөө санал хэлчихлээ. Х.Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Хоёр, гурван асуулт байгаа юм. Нэгдүгээр асуулт болохоор бид 2021 оны 01 сарын 21-нд Банкны хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тийм ээ.

Тэр Банкны хуулиар хэд хэдэн шаардлагуудыг банкнууд хангах ёстой болсон. Нээлттэй хувьцаат компани болгох, 20 хүртэл хувийн хувьцааг төвлөрөлтэй болгох энэ тэр гээд. Тийм ээ.

5 банк хувьцаа гаргасан. 20 хүртэл хувийн төвлөрлийн асуудлыг “Хас”

банкнаас бусад банк аль нь ч биелүүлээгүй байна.

Тэгээд энэ чуулган хуралдтал ер нь Монголбанкны Ерөнхийлөгчийн хэд хэдэн ярилцлагыг харлаа. Санаатай болон санамсаргүй энэ Банкны хуулийг хэрэгжүүлэх сонирхолгүй байгаа гэж харагдаж байна.

Тэр нь юугаар үндэслэгдэж байна вэ гэхээр одоо энэ 5 банкнаас, “Хас” банкнаас бусад нь тэр шаардлагаа биелүүлэх гэж явж байгаа нэг ч банк алга байна.

Хувьцааны ханш унаж байгаа мэтээр ярьж байна. Тэр хувьцааны ханш унаж байгаа гэдэг чинь одоо яг бодит ханш дээрээ л очиж байгаа шүү. Та нар хувьцааг нь гаргаж байх үед Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо дуудлага худалдааны зарчмаар ч юм уу явсан бол тэр хувьцаа чинь бодит ханшаар гарах байсан юм.

Нэрлэсэн үнээ хэт өндөр тавиад тэгээд жижиг хувьцаа эзэмшигчид тэр хувьцааг нь авангуут хоёр дахь зах зээл дээр очоод л нөгөө хувьцаа нь унаж байгаа байхгүй юу. Тэгээд бодит ханш дээрээ л очиж байгаа гэсэн үг.

Тэгэнгүүт банкуудын үнэлгээ унаад байна гэсэн байдлаар тайлбар тавьж байгаа харагдсан.

Одоо энэ мөнгөний бодлого дээр гадаадын банкиг оруулж ирэх гэж байгаа юм гэдэг нэг тайлбар яваад байгаа юм.

Тэгээд гадаадын банкууд орж ирэхийн тулд 34 хувиас дээш хувьцааг авах ёстой юм гэдэг ярилцлагыг би 3 удаа харсан. Одоо энэ Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Тэгээд нэг ёсондоо 20 хувь гэдэг төвлөрлийг 34 хувь болгоно гэсэн байдлаар Банкны хуулийг өргөн барина гэсэн байдлаар ярилцлагыг би бас харлаа.

Тэгэхээр та энэ Банкны хуулийг. Та хууль хэрэгжүүлэх үүрэгтэй хүн шүү дээ. Тийм ээ. Хууль хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ хууль батлагдаад 2 жил ч болоогүй байна. Энэ хууль батлагдсан үндсэн шалтгаанаа та өөрөө мэдэж байгаа байх. Гишүүд ч мэдэж байгаа, ард түмэн ч мэдэж байгаа.

Яагаад энэ хууль батлагдсан бэ гэхээр төр банкны тэр мафи гэх юм уу, юу гэх юм. Хулгай нь дэндсэн болоод л энэ банкны хуулийг баталсан шүү дээ. Энэ Банкны хууль олон улсын жишгийг харж байгаад л бид Банкны хуулийг баталсан.

Одоо эргээд танд сануулья. Эрдэнэтийн 49 хувь, Дархан, Хөтөл. Одоо сүүлд ил болчхоод байгаа нууц гэрээ, Голомт банк гээд л энэ бүхэн чинь бүгдээрээ л банктай холбоотой шүү дээ. Банкны эзэд чинь банкиг ашиглаж хулгай хийгээд байгаа болохоор бид энэ төвлөрлийг нь 20 хүртэл болгосон байхгүй юу.

Та тэгээд өнөөдөр буцаагаад тэр хуулийг нь 34 хувь руу болгох гээд ярилцлага өгөөд яваад байгаа байхгүй юу. Одоо Банканд нэмэлт, өөрчлөлт оруулна гээд яриад яваад байгаа.

Танд одоо үндсэндээ 3 сарын л хугацаа байна. Хуулийг хэрэгжүүлэх. Хэрэгжүүлэхгүй бол би энэ ард түмэнтэйгээ ёстой гараад нэг талдаа гарна. Банктай холбоотой асуудлыг бид ил тод, нээлттэй яриад л явна гэсэн үг. Хариуцлагын асуудлыг ярина л гэсэн үг. Тэгээд энэ дээрээ танаас нэг хариу авчихмаар байна.

Хоёрдугаарт, инфляцыг онилно гэгчхсэн байна л даа. Яах вэ, бодлогын хүү буурахгүй гэж ойлголоо. Зээлийн хүү буурахгүй юм байна. Тэгээд яах вэ, ипотекийн зээлийг танайх буцаагаад авч байгаа юм байна. Танайх ипотекийн зээл буцаагаад олгож эхлэх юм байна. Эх үүсвэр нь хаанаас яаж эх үүсвэр гаргах билээ. Эргэн төлөлтөөсөө гаргах юм уу?

Тэгэхээр энэ ипотекийн зээлийн хэмжээ чинь буцаад хэвийн байдалдаа очно гээд та сая хэлчих шиг боллоо. Тэгээд ирэх жил ямар хэмжээний мөнгийг ер нь ипотекийн зээл буцааж гаргах юм. Энэ чинь одоо тэгэхгүй бол өртөг нь асар үнэтэй болчихоод байна шүү дээ.

Мөнгөний өртөг өөрөө дэлхий даяар. Дэлхий даяар бүх улс орнууд инфляцыг онилж байна. Америкийн Засгийн газар хүртэл 8 хувийн хүүтэйгээр мөнгө зээлж байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг 3 номер хариулъя.

Б.Лхагвасүрэн: Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Тэгээд 2021 оны 01 сарын 27-нд Улсын Их Хурлаас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад ямар ч байсан банкны секторын нөлөө бүхий банкуудыг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгохоор хуулийн зохицуулалт оруулж өгсөн.

Хоёр гол нэг зүйл нь нэг нь саяын миний хэлсэн том банк нээлттэй хувьцаат компани байх. Бусад жижиг банкууд зүгээр хаалттай хувьцаат компани байж болно.

Ямар ч байсан хөрөнгийн биржид бүртгэлтэй байхаар.

Хоёр дахь гол зохицуулалт нь хөрөнгийн төвлөрөл. Тэрийг 20 хувьд хүргэж нэг хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн төвлөрлийг 20-иос хэтрүүлэхгүй байхаар ийм хоёр хуулийн заалт байсан.

Эхний хуулийн заалт 2022 оны 6 сарын 30-наар хэрэгжих ийм хуулийн хугацаатай. Хоёр дахь 20 хувийн заалт нь энэ 2023 оны 12 сарын 31-нээр. Ийм хоёр хуулийн заалт байгаа.

Өнгөрсөн оны 6 сард хэрэгжих ёстой байсан IPO хийх заалт нь Олон Улсын Валютын Сангаас активын чанарын үнэлгээ хий. Зайлшгүй шаардлага байна. IPO гаргахаас өмнө гэдгээрээ ингээд нэг жилээр хойшлогдоод сая 6 сарын 30-нд хугацаа дууссан.

Худалдаа, хөгжлийн банк, ХААН банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк гэсэн ийм 5 том банк өөрийн хувьцааны 5-аас 10 хувийг олон нийтэд нээлттэй арилжаалж энэ хэсгээ хувьчлуулсан байгаа.

Тэгээд нийт 470 тэрбум төгрөгийн хөрөнгө боссон. 5-аас 10 хувиа хувьчлахад.

Тэгээд ямар ч байсан Хөрөнгийн биржийн өөрийнх нь капиталжилт гэдэг. Хөрөнгийн биржид байгаа бүтээгдэхүүний нийт үнийн дүн анх удаагаа 10 их наядыг давсан байгаа.

Тэгэхээр Банкны IPO-гоор энэ хэмжээний хөрөнгө босож явж байгаа. Яг өнөөдөр хувьцааны үнэ ханш яг тийм тогтвортой өсөж байгаа ч юм уу, тогтвортой хэмжээнд биш. Ерөнхийдөө жоохон бууралттай байгаа.

Одоо дөнгөж 5-аас 10-хан хувийнхаа хувьцааг арилжаалахад 470 тэрбум төгрөгийг хөрөнгийн биржээс

босгосон. Өнөөдрийн хөрөнгийн бирж дээр байгаа хувьцааны үнэ ханш ерөнхийдөө ямар ч, зөвхөн банкны ч биш бусад хувьцааны үнэ ханш ч гэсэн тэгж их огцом өсөхөөр тийм зүйл байхгүй.

Яагаад гэвэл бирж өөрөө ингээд жижигдээд байгаа юм. Энэ нөгөө ликвидност буюу тэр чөлөөтэй хөрвөдөг эх үүсвэр хөрөнгийн биржид байхгүй болчихоод. Хувьцаа бие бие рүүгээ ерөөсөө орж гардаг ийм хөдөлгөөн байхгүй болчихоод байгаа нь өөрөө дараагийн энэ хоёр дахь заалтыг хэрэгжүүлэхэд их түвэгтэй байна л гэдэг ийм суурь нөхцөлийг л бүрдүүлчхээд байгаа юм.

Өөр нэг зүйл нь 07 сарын 01-нд эдийн засгийн форум зохион байгуулсан. Энэ удаагийн форумд маш олон улс орны их олон хөрөнгө оруулагчид ирсэн.

Тэр таны дурдаж байгаа миний хэвлэлд өгсөн ярилцлагад байгаа тэр 33, 34 гэдэг тоог би өөрөө хэлээгүй. Тэр Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгч эдийн засгийн форум дээр үг хэлэхдээ ялангуяа тэр банк, санхүүгийн салбарын хуралдаан дээр үг хэлэхдээ энэ 20 гэдэг тоо бага байна. Гаднын хөрөнгө оруулагчид сонирхохгүй. Ялангуяа Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк бол үүнээс илүү хувиар авах хүсэлтэй байна гэдгийг тэнд дээр илэрхийлсэн учраас би тэр хөрөнгө оруулагчдын санал ингэж явж байна шүү гэдгээрээ тэрийг зүгээр хэвлэл мэдээлэлд хэлсэн.

Тэгэхээр ялангуяа гаднын хөрөнгө оруулагчид манай Банкны хууль дотор байгаа тэр хязгаарлалт ерөнхийдөө хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж байна гэж хэлж байгаа. Ялангуяа жижиг банк дээр 20 гэдэг бол жижиг банкныг 20 хувийг нь авчхаад ямар ч шийдвэр

гаргахад нөлөө орохгүй учраас тэр жижиг банкныг авах сонирхлыг бүр төрүүлэхгүй байна гэдгээрээ асуудлыг ингэж гаргаж ирсэн. Тэр утгаараа зүгээр одоо хийх хуулийн өөрчлөлт дээр энэ саяын.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүн нэмж асуулт асууя. 1 минут.

Х.Ганхуяг: Тэгэхээр би нэг юм асуусан шүү дээ. Та хуулийг хэрэгжүүлэх үү, үгүй юү гэдэг л асуултыг асуусан.

Эргэж тойруулаад байх хэрэггүй. **Dual listing**_[давхар бүртгэл] хийх аргачлал байна. Монголын хөрөнгийн бирж багадаагүй. Сингапур, өөр юу байдаг юм, Торонто, Канад, Австрали, “**дуал листинг**” хийх аргачлал зөндөө байна.

Тэгээд та бодлогоо барьж явах юм уу? Европын сэргээн босголтын банк таны бодлогыг чинь гаргаж өгөх юм уу?

Та тэгээд хууль хэрэгжүүлэх эсэхээ л надад хариуг нь өгчих.

Тэгээд хоёрдугаар асуудал. Одоо яах вэ, өнөөдөр бол ингээд мөнгөний бодлогоо бид хатуу барьсан нь ханшны уналтыг бид барьж чадаж байгаа байхгүй юу. Тэгэхдээ 2800 байсан ханшийг 3400 болтол нь алдсан алдаа блд таны алдаа шүү.

Ч.Хүрэлбаатар сайд танд нэг бус удаа анхааруулж байсан шүү дээ. Төсвийн бодлого ингээд тэлэлттэй явж байвал мөнгөний бодлогоо хатууруулаач ээ гээд.

2, 3 жил та алдсан. Одоо иргэд энэ ханшийн алдагдлыг танаас нэхэх эрхтэй шүү, ер нь бол.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг 3 номер. Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө сүүлийн 3 жил бол КОВИД-ын 2 жил, өнгөрсөн оны эдийн засгийн тэр түвэгтэй байдлын ийм 1 жил, хүнд 3 жил өнгөрсөн.

Төгрөгийн хувьд өнгөрсөн онд ханшны алдагдал 20 хувь долларын ханш суларсан. Энэ 20 хувийн сулрал бол дэлхийн дундаж сулрал байгаа. Зарим улсуудын, ялангуяа өнөөдөр Монголоос өндөр хөгжилтэй Японы иен 30 гаруй хувиар суларчхаад ингээд явж л байгаа.

Тэгэхээр энэ угаасаа л нөхцөл байдлын хувьд ийм л байсан.

Хоёрдугаарт, экспорт, импортын зөрүүн дээр энэ ханш тогтдог. Ялангуяа экспорт нь их байх юм бол Монгол Улсын валютын нөөц нэмэгдээд ханш илүү тогтвортой байдаг. Хэрвээ экспорт байхгүй байх юм бол Монгол Улсад орж ирэх валютын нөөц байхгүй, валютын урсгал байхгүй гэдгээрээ төгрөг өөрөө зах зээлийнхээ тохируулгыг хийгээд л ингээд сулраад л явж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Х.Ганхуяг гишүүн хариулт хангалтгүй гэж үзсэн учраас нэмж тодруулж асууя.

Х.Ганхуяг: Банкны хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа нь банкны эздийн буруу биш байхгүй юу.

Та бүхэн маань банкны хуулийг хэрэгжүүлэх тал дээр ажиллахгүй байна. Та ерөөсөө Банкны хуулийг хэрэгжүүлэх эсэх тал дээр надад хариу өгсөнгүй.

КОВИД-ын үед угаасаа ойлгомжтой байсан шүү дээ. Экспорт гарахгүй байна. Манай валютын нөөц хязгаартай. Тэгсэн мөртлөө мөнгөний бодлогын хүү нь 6 хувьтай, 6.5 хувьтай яваад байгаа чинь наад ханш чинь алдах нь тодорхой л байсан шүү дээ.

Тэгээд би таныг бүр 2022 оны мөнгөний бодлогыг хэлэлцэж байх үед би танаас асууж байсан. Та инфляцаа яаж нэг оронтой тоон дээр барих гээд байгаа юм бэ. Та итгэлтэй байна уу. Та итгэлтэй байна л гэж байсан. Тэгээд л 3400 руу дахиад очсон шүү дээ.

Энэ чинь ерөөсөө 2 жилийн өмнөх л асуудлыг би яриад байна шүү дээ. Эсвэл би тэр үеийн бичлэгийг олж байгаад явуулах уу тань руу, эсвэл олон нийтэд танилцуулах уу.

Хариулахгүй байна шүү дээ. Ерөөсөө.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер.

Б.Лхагвасүрэн: Х.Ганхуяг гишүүний асуултад нэмж тодруулъя.

Банкны хуулийн хэрэгжилтийг угаасаа Төв банк хуулиар хүлээсэн үүрэг учраас хэрэгжүүлээд явна.

Хэрвээ одоо энэ 20 хувийнхаа хэрэгжилтэд орохгүй бол угаасаа хуулийн заалт байгаа. 20-иос илүү гарсан хэсэг нь тэр банкны санал өгөх эрх нь эзний, хөрөнгө оруулагчийн санал өгөх эрх нь хязгаарлагддаг.

Тэгэхээр энэ хязгаарынхаа дагуу л хууль хэрэгжээд явна. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: Ж.Ганбаатар гишүүн асуултаа асууя. Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Эдийн засгийн байнгын хорооны гишүүний хувиар асуулт асууя.

Сая Ерөнхий сайдтай хөдөө орон нутгаар явж байхад хоёр, гурван асуултууд их тийм зүрх зүсэж байна лээ л дээ. Бүх шатны зээл бараг 25-аас дээш. Хөдөө орон нутагт. Тэгээд зээлийн хүү төлсөөр байгаад л хийж бүтээж байгаа амьдрал маань дууслаа гэсэн ийм зүйл ярилаа.

Тэгэхээр би юу хэлэх гэж байгаа вэ гэхээр яах вэ, энэ бодлогын хүүг чангаруулаад, валютын нөөц нэмэгдүүлээд, нэг талыгаа хараад байж магадгүй. Нөгөө талдаа аж ахуйн нэгжүүд ер нь бизнес хийгээд энэ хүүг давахгүй юмыг чинь ямар ч боломжгүй л байна л даа. Тэгээд бүгдээрээ л төрийг харж байна л даа. Тэгээд яг яах вэ гэж. Хэр удаан ингэж явах вэ?

Тэгэхээр нэг талыг нь чангаруулаад болчихдог, нөгөө талд нь бид Монголбанк яах вэ гэдэг дээр нэг хариулт өгвөл.

Би үүнийг Засгийн газар дээр ч гэсэн ярьж байсан л даа. Таныг нэг орж ирж юм танилцуулахад. Та нэг л удаа орж ирсэн л дээ. Угаасаа Засгийн газар луу нэг их орж ирээд байх шаардлага ч байхгүй л дээ.

Тэгээд яах вэ, валютын нөөц 4.2 тэрбум, Монголбанкны үнэт цаасны үлдэгдэл бараг 7 их наяд хүрч байгаа юм байна лээ шүү дээ. Энэ бас нэг их сайн тоо биш шүү. Тэр сайн үзүүлэлт биш. Уг нь зах зээл рүү мөнгө гаргамаар байх юм. Хүмүүс амьдармаар байх юм. Тийм ээ.

Тэгээд бүх зүйлээ нааш нь цааш нь чангалчихаар одоо тэгээд.

Би яах вэ, Ч.Хүрэлбаатар сайдтай ийм асуудал дээр зарим зүйл дээр санал зөрдөг л юм л даа. Энэ бизнес эрхэлж байгаа хүмүүс. Ялангуяа жижиг, дунд бизнес эрхэлж байгаа хүмүүс үнэхээр зээлийн хүүд яаж байна л даа. Энэ талаар юу бодож байгаа бол? Үүнийг яаж балансжуулах вэ? Тийм ээ. Нэгэнт л мөнгөний бодлогыг барьдаг байгууллагын хувьд үүнийг яаж балансжуулах вэ? Нэг талд нь яаж савуулахгүй байх вэ л гэсэн асуулт шүү дээ. Тийм ээ.

Тэгээд л валютын нөөцөө нэмэгдүүлнэ, тэгээд инфляцыг алдахгүй гээд явчихаар тэгээд цаана үүнийг даваад амьдрах бололцоотой бизнес гэж байхгүй байна л даа. Монголд. Тэгээд яах вэ гэдэг ийм зүйл байна.

Хөдөө орон нутгаар яваад хүмүүсийн яг бодитой асуултууд бол эвгүй л сонсогдож байна лээ л дээ. Олон аймаг дээр давтагдаж байна лээ. Нэг хариулт сонсчихоод тодруулъя. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер хариулъя.

Б.Лхагвасүрэн: Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Тийм. Ерөнхийдөө ер нь балансжуулна гэдэг дээр л Монголбанкны бодлого л яваад байгаа л даа. Тэрийг яаж тайлбарлах вэ гэхээр нэгэнт манай инфляцын бараг 50 хувь нь, манай сагсны 400 гаруй бүтээгдэхүүний 50 хувь нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа юм.

Тэгэхээр импортоор орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүний үнэ тогтвортой байхад ханш л хамгийн гол нөлөөтэй байгаа юм.

Тэгэхээр ханш хэрвээ сулраад л байх юм бол импортоороо ханшныхаа зөрүүгээр бараа, бүтээгдэхүүний үнэ өсөөд байх гэдэг үүднээсээ ерөнхийдөө нөөцөө нэмэгдүүлээд ханшаа тогтвортой байлгая гэдэг л. Нөөц нэмэгдүүлэх гол бодлогын сонголт нь байсан.

Хоёрдугаарт, сая төсвийн тодотголоор 1.8 их наядар төсвийн зардал нэмэгдээд, эргээд инфляц дээрээ дарамттай гарна гэсэн тооцоо судалгаа, ялангуяа Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамны тухайн үед гаргаж байсан судалгаагаар 2 хувийн дарамт байна гэдгээр гарч ирсэн учраас бодлогын хүүгээ 13 хувиас доош нь бууруулах орон зайг олж харж чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр тэр утгаараа 13 хувийн бодлогын хүү өнгөрсөн оны сүүлээс хойш бараг бүтэн нэг жил гаруйн турш ийм өндөр хэвээрээ хатуу хэлбэрээрээ яваад байгаа.

Тэгэхээр аль болохоор инфляц өөрөө нам доор түвшин рүү орж ирж, ялангуяа Монголбанкны зорилтот түвшин рүү орж ирэх юм бол Монголбанк бодлогын хүүгээ буулгаад, зөөлрүүлээд явах боломжтой л гэж хэлье.

Тэгэхээр энэ бүх зүйл аль болохоор тэр баланс, тэнцвэрийг барих л ийм зорилготой л бодлого явж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө, одоо ингээд л мөнгөний ханш ийм байдалтай унаад л. Тийм ээ.

Дээрээс нь зээлийн хүү буурахгүй байх юм бол тантай л яриад байна шүү дээ. Гишүүд бүгд л тань руу хандана шүү дээ.

Тэгээд та тэр дээр Монголбанкныхаа байр суурийг хатуу

тодорхой илэрхийлээд. Эцсийн эцэст бодлогын хүү буурахгүй, ялангуяа хувийн хэвшлийнхнийгээ, тэгээд жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг жижиг бизнесийг нь борцлоод, хатаагаад дуусгачих вий гэж хүмүүс их болгоомжлоод байгаа шүү.

Ингээд энэ асуултууд цаашдаа их асуугдах байх. Монголбанкныхан бодлого, байр суурийг тодорхой хатуу хэлж байх хэрэгтэй шүү.

М.Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Монголбанкны 2023, 2022 онд ихэвчлэн инфляцыг онилох, ингэснээрээ мөнгөний бодлого, төсвийг уялдуулаад зах зээлд хөрөнгө оруулалтыг дэмжих, мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх бодлогыг онц буцалж барина гэсэн.

Энэ нь өөрөө эцсийн үр дүн нь юу байх вэ гэхээр аль болох олон ажлын байрыг хадгалах, ажлын байрыг нэмэгдүүлэх энэ зорилт гэдэгтэй та бүхэн маань санал нийлж байна гээд ярьж байсан. Бас энэ дагуу жишээ нь ногоон тогтвортой хөгжлийн зээл, бусад зээлийн хэлбэрүүдийг нэмэгдүүлж, энэ нь өөрөө ажлын байрыг хадгалах, ажлын байрыг нэмэгдүүлэх үндэс болж өгнө гэж бид тооцоолж байгаа гээд та бүхэн 2023 оны мөнгөний бодлого дээрээ хэлж суулгаж баталсан.

Тэгвэл одоо та нар 2023 онд энэ баталсан мөнгөний бодлогын хүрээнд ажлын байр хэдээр нэмэгдсэн, аль салбарт яаж нэмэгдсэн гэсэн тооцоо, судалгаа надад хэлж өгөөч. Энэ нь өөрөө өнөөдөр яригдаад байгаа үнэхээр Монголбанк ашигтай, хүү багатай зээлээр хөрөнгө оруулагчдаа дэмжээд, энэ нь өөрөө шинээр ажлын байр бий болгосон

нөхцөл дүр зураг жишээлбэл нэг л харагдахгүй байгаад байна.

Тэгэхээр энэ дээр нэг тайлбар авъя гэж бодож байна.

Хоёр дахь чухал зүйл нь бүгд л яриад байна л даа. Ипотекийн зээлийг 2023 онд Олон Улсын Валютын Сангийн зөвлөмжийн дагуу Засгийн газар луу шилжүүлээ гэсэн. Одоо буцаагаад Монголбанк руу шилжиж ирж байна гэж би ойлголоо.

Тэгээд энэ дээр 2024 оны төсвийн төсөөлөлд ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр төсөв мөнгөний бодлогыг уялдуулж төрөөс баримтлах мөнгөний бодлогод тодорхой тусгаж өглөө гэж хэлсэн л дээ.

Тэгэхээр яаж ипотекийн зээлийг нэмэгдүүлэхийн тулд төсөвтөө яаж уяад, мөнгөний бодлого дээрээ жишээ нь яаж тусаж орж ирж байгаа юм. Мөнгөний бодлого дээрээ тусаж орж ирсэн төсөвт тэгвэл санхүүжилт, ипотекийн зээл дээр тусгах энэ тооцоогоо Сангийн яамтайгаа яриад одоо 2024 оны төсөв дээр ямархуу хэмжээний санхүүжилтийг ипотекийн зээлд тусгана гэж тооцоолж орж ирж байгаа вэ?

Яг ийм зүйлийг хэлсэн л дээ. Төсөв, төрөөс баримтлах мөнгөний бодлоготой уялдуулж ипотекийн зээлийг нэмэгдүүлэх бодлого барьж байгаа талаар ярьж байгаа.

Тэгэхээр энэ дээр яг тодорхой хариулт өгөөч. Хэдэн хувийн хүүтэй, хэдий хэмжээний санхүүжилтийг 2024 онд ипотекаар гаргахаар төсөв мөнгөний бодлого хоёрт яаж тусгасан байгаа вэ гэдгийг бас асуухыг хүсэж байна.

Гурав дахь нэг зүйл байгаа юм. Монголбанк шинээр ингэж байгаа юм

байна л даа. Одоо инфляцыг онилох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх дэд бүтцийг дараагийн шатанд гаргах шинэ зорилтыг дэвшүүлж орж ирж байна гэж байна.

Тэгэхээр энэ одоо яг юу гэсэн үг вэ? Ямар дэд бүтцийг шинэ шатанд гаргаад. Ингэснээрээ инфляц, мөнгөний бодлого ханшид энэ яаж нөлөөлөх юм? Үүний дэд бүтэц нь гэж яаж бүрдэнэ гэсэн үг вэ? Тэгээд энэ дээр бидэнд тодорхой хэлэхгүй бол нэг л гоё үг, хэллэг байгаад байдаг. Үүнийгээ задлаад бид үр дүн, чанарыг нь үзэх гэхээр тооцоолол нь харагдахгүй байгаад байна.

Тэгэхээр үүнийг нэгд хариулж өгөөч гэж асуумаар байна.

Эцэст нь сая гадаадын хөрөнгө оруулалттай банкыг оруулж ирэх бодлогыг барьж байна гэж байна. Яг ямар гаднын банк манай улсад банк, санхүүгийн салбарт хөрөнгө оруулалт хийж орж ирэх сонирхлоо илэрхийлсэн байгаа вэ?

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр **Bank of China** орж ирж магадгүй гэсэн мэдээллүүд явж байна лээ. Тийм ээ. Хэрвээ үнэхээр ингэж орж ирэх гэж байгаа бол одоо яг хөрөнгө оруулалтыг аль салбарт ямар хязгаарлалт тогтоох вэ энэ тэр гээд Монголбанк бодлогын түвшинд зарчмаа, дүрэм журмаа, тоглоомын дүрмээ тогтоочихсон байгаа юу гэсэн энэ асуултуудыг эхлээд хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер. Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Тийм. Ерөнхийдөө мөнгөний бодлого хатуурч явж байгаа нь өөрөө эргээд л эдийн засгийн өсөлтийг хязгаарлах, ялангуяа бизнес томрохыг л хязгаарласан ийм л бодлого л доо.

Тэгэхдээ яалт ч байхгүй түрүүн би гишүүдийн асуултад хариулахдаа нэгэнт төсөв ингээд өндөр тэлэлттэй байгаа учраас мөнгөний бодлогод ийм хязгаарлахаас өөр орон зай байхгүй.

Төсвийн тэлэлтээр мэдээж эдийн засгийн эрэлт талаасаа өдөөгдөж сэргэж байгаа. Түүнд нь тохирсон мөнгөний бодлого явж байгаа. Мэдээж мөнгөний бодлогыг маш огцомоор. Түрүүн гишүүдийн асууж байсан шиг тэр үед их огцом өсөх ёстой байсан гээд. Тэр үед огцом өсгөсөн бол өнөөдрийн таны асууж байгаа ажиллах хүчний оролцоо ч гэдэг юм уу, эсвэл эдийн засгийн өсөлт ингээд 6.4 хувийн өндөр түвшинд байхгүй байсан.

Огцом чангаруулаагүй, зуугуухан чангаруулсны үр дүн өнөөдөр ингээд эдийн засгийн өсөлт 6.4.

Танд би бас нэг тоо хэлэх гэж байна. Энэ ажиллах хүчний оролцооны түвшин 2022 онд 57.9 байсан бол өнөөдөр ингээд 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 57.9. Оролцооны түвшин хэвээрээ байна гэсэн үг.

Тэгэхээр өөрчлөгдөөгүй. Тэгэхээр ажлын байр хадгалагдаж чадсан л гэж л хэлэх гээд байгаа юм. Энэ нь өөрөө тэрийг л харуулж байгаа үзүүлэлт учраас. Тэр утгаараа ямар ч байсан эдийн засгийн өсөлт 6.4 хувьтай гараад, ажиллах хүчний оролцооны түвшин яг хуучин тэр хэмжээндээ байж чадаж байна гэдгээрээ энэ нь тайлбарлагдаж байгаа юм гэдгийг хэлье. Тийм.

Ер нь яах вэ, шинээр ажлын байр гэдэг дээр ялангуяа хөдөө аж ахуйн салбар луу нэлээн хөнгөлөлттэй зээлүүд гарч явж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний аюулгүй байдал, хүнсний хувьсгал”-ын хүрээнд хөнгөлөлттэй хүүтэй 400 тэрбум төгрөгийн зээл гарсан байна. Энэ 400 тэрбум төгрөгийн зээл Монголбанкны мөнгө биш. Энэ бол арилжааны банканд дээр чөлөөтэй хэлбэрээр байсан мөнгийг хүүгийн хөнгөлөлт үзүүлэх замаар гаргасан зээл.

Тэгэхээр хөдөө аж ахуйн салбарт ялангуяа тэр хүнсний ногоо тарьж байгаа газар тариалангийн салбарт нэлээн олон ажлын байр нэмэгдсэн гэсэн тоонууд явж байгаа.

Хоёр дахь асуултын хувьд, ер нь өнгөрсөн онд ялангуяа энэ ипотекийн зээлийг Засгийн газарт шилжүүлээ гэдэг үүргийг Улсын Их Хурлаас Монголбанканд өгсөн. Энэ тогтоолоор гарсан байгаа.

Тэгээд эхний хагас жилдээ багтааж шилжих ёстой байсан. Тэгээд Барилга, хот байгуулалтын яам ажлын хэсэг гараад шилжүүлж авахаар ажиллаж байсан ч гэсэн яг 07 сарын 01-нд бид үүнийг шилжүүлж авч чадахгүй юм байна. Тийм хүчин чадал алга гэдгээр шилжүүлж авахгүй гээд хариу өгсөн.

Тэгээд нэгэнт Монголбанкны хувьд 2013 оноос хойш энэ ипотекийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Өнөөдрийн байдлаар манай Монголбанкнаас гарсан эх үүсвэр нь өөрөө 3.6 их наяд болсон.

Тэгэхээр 3.6 их наядын эх үүсвэрийг хэн нэгэн хүн менеж удирдлага болгож авч явж эргэн төлөлтийг нь хариуцах ёстой. Нэгэнт Засгийн газар өөр дээрээ шилжүүлж авахгүй гэсэн учраас

Монголбанк энэ ажлаа өөр дээрээ хадгалаад явж байгаа.

Засгийн газрын хувьд Үндэсний ипотекийн корпорац гэдэг агентлагийг байгуулъя. Үүндээ зориулсан хууль эрх зүйн орчныг бий болгоё гэдгээрээ өөрсдөө санал тавиад явж байгаа учраас тэр агентлагийг бий болж шилжүүлж автал Монголбанк өөрөө үүнийгээ хариуцаад явахаас өөр аргагүй байгаа.

Жилдээ 600 орчим тэрбум төгрөгийн ипотекийн зээл, эх үүсвэр гарч байвал ипотекийн энэ орон сууцын хөтөлбөр өөрөө хэвийн хэмжээнд хадгалагдах ёстой. Бидний 3.6 их наядын эх үүсвэрээс жилдээ 350 тэрбум төгрөг төлөгддөг.

Тэгэхээр 600 болохын тулд цаана дахиад 250 тэрбум төгрөгийн эх үүсвэр зайлшгүй шаардлагатай байгаа.

Тэгэхээр энэ их хэмжээний эх үүсвэрийг Монголбанк өөрөө гаргахгүй гэвэл хэнээс нэмж гаргуулах вэ гэдгээрээ Дэлхийн банк болон бусад байгууллагуудтай бас яриа хэлэлцээ хийгээд явж байгаа.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай, ялангуяа тэр Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрийг ч гэсэн энэ рүү оруулах боломж бололцооны талаар ажлын хэсэг гаргаад судлаад явж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: М.Оюунчимэг гишүүн нэмэлт асуулт асууя. 1 минут.

М.Оюунчимэг: Та одоо асуултад хариулахдаа миний сүүлийн асуулт дэд бүтэц шинэ шатад гаргана гэдгээ хариулчхаарай.

Сая та хэлж байна л даа. Энэ төсөв болоод төсвийн төсөлд төрөөс баримтлах

мөнгөний бодлогын 2024 онд ипотекийн зээлийг нэмэгдүүлэхээр тодорхой тусгалаа гэж Засгийн газраас хэлээд байна шүү дээ.

Тэгэхээр 2024 оны төсвийн төсөл өргөн баригдчихсан. Өнөөдөр төрөөс баримтлах мөнгөний бодлогын хэлэлцэх эсэхийг одоо ярьж байна. Яг энэ хоёр маань уялдаад ипотекийн зээл дээр тодорхой санхүүжилтийг одоогоор би тусгаагүй юм байна гэж ойлголоо шүү дээ. Таны ярьснаар. 600-аад тэрбум төгрөг шаардлагатай.

Тэгэхээр энэ эх үүсвэрийг хаанаас олох вэ? Олон улсын байгууллагуудтай ярих гээд бүрхэг ярьж байна шүү дээ.

Тэгэхээр төсөвтэй уялдаагүй л байна даа. Тийм ээ.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 1 номер нэмэлт хариулт өгье.

А.Энхжин: Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин. М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

2024 оны улсын төсөвт яг энэ орон нутгийн зээлийн 3 хувийн дотацид зориулаад 16 тэрбум төгрөг суулгасан байгаа.

Тэгэхээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Хөдөөгийн хөгжил, хөдөөгийн сэргэлт хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанкнаас гарах эх үүсвэрийн ер нь 50 хүртэл хувийг нь орон нутагт зориулж гаргая гэсэн тийм төлөвлөгөөтэй. Үүнийгээ Засгийн газартай хамтраад хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Тэгэхээр үүнтэй уялдуулаад энэ жил 8 тэрбум байсан 3 хувийн хүүгийн

татаасыг ирэх жил 16 тэрбум болж нэмэгдүүлж байгаа.

Тэгэхээр 16 тэрбум төгрөгийн дотациар нийтдээ 4300 орчим зээлдэгчийн хүүгийн дотацийг өгөхөөр төлөвлөж байгаа.

Тэгэхээр Монголбанкны санал бол улсын төсөвт тусгагдаад хэрэгжиж байгаа.

Монголбанкны зүгээс энэ ипотекийн хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах шаардлагатай байгаа.

Тэгэхээр энэ оны эхний хагаст багтаагаад Монголбанкийг шилжүүл гээд үүрэг өгөгдсөн учраас үүнтэй нийцүүлж Монголбанк цаашид хэрхэн ажиллах вэ гэдгээ бас тодорхой болгох шаардлагатай байгаа юм.

Тэгээд энэ асуудал шийдэгдвэл яг Ерөнхийлөгчийн хэлдгээр 600-аас 700 тэрбум төгрөгийн ипотекийн зээл цаашдаа жилд.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Нэмж ажлын хэсгийн 2 номер.

Б.Баярдаваа: Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа.

М.Оюунчимэг гишүүний асуултад хариулья.

Инфляцыг онилох мөнгөний бодлогын хэлбэрийг сүүлийн 10 гаруй жил үе шаттайгаар Монголбанк хэрэгжүүлээд явж байгаа. Сүүлийн үе шатан дээр хэд хэдэн зүйл яригдаж байгаа нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн шинэчлэлийн асуудал Төв банкны

тухай хуультай холбоотой бид төлөвлөж байгаа. Ирэх жил Эдийн засгийн байнгын хороо Улсын Их Хуралтай хамтраад дараад энэ зүйл дээр ажиллахаар төлөвлөж байгаа.

Хоёр дахь зүйл нь, өнөөдөр гишүүд бас асуугаад байгаа нэг зүйл нь инфляцыг тодорхойлж байгаа хамгийн том хүчин зүйл төсөв, дээрээс нь хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлтийн гинжин хэлхээ гэдэг зүйл өөрөө инфляцыг Төв банкны зорилтод тогтворжуулахад маш том саад болж байгаа.

Энэ чиглэлийн эдгээр зүйлүүдийг сайжруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа.

Нөгөө талаасаа санхүүгийн зах зээл дээр бизнест шаардлагатай байгаа санхүүгийн бүтээгдэхүүнийг эрэлт хэрэгцээнд нь нийцүүлж хөгжүүлэх шаардлагууд байгаа. Ийм зүйлүүд дээр их анхаарахаар байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Та хариулт хангалтгүй гэж үзэж байгаа бол дахиад нэмээд 1 минут өгье. М.Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Би ажлын байр нэмэгдсэн тооцоо, судалгааг яагаад асуугаад байна гэхээр одоо Их Хурал төсөв хэлэлцэнэ.

Тэгэхээр бид урьдчилаад Төрөөс баримтлах мөнгөний бодлогоо хэлэлцэх гээд орж иржээ. Энэ хоёр чинь уялдаж байж ажлын байрыг. Одоо бараг царцанги байдалтай байгаад байна шүү дээ. Тэр ажиллах хүчний түвшин 57.9 яг л хэвээрээ. Тэгээд буурсан нь, өссөн нь ч байхгүй.

Тэгэхээр энэ чинь юу гээд байна гэхээр Төрөөс баримтлах мөнгөний бодлого маань төсөвтэйгөө уялдаад аль болохоор ажлын байрыг илүү хөхиүлэн дэмжиж, ингэснээрээ эргэлдэж байгаа бизнес, өрхийн орлого нэмэгдэх үндэс болж өгдөг. Энэ чинь л явахгүй байгаад байна л даа.

Тийм ч учраас өөрөө түрүүн хэлж байна. Эдийн засгийн өсөлтийг хязгаарлах бодлого бодлогын хүүгээрээ барьсан гэж байна. Энэ мэдээж төсөв тэлсэнтэй холбоотой л байх.

Тэгэхээр Монголбанк маш тийм зоригтой бодлогоо хэрэгжүүлээд, үүнийгээ бид Их Хурал дээр төсөвтэйгөө уяад хэрэгжүүлэх хэрэгтэй байна шүү дээ. Тэгэхгүй бол яг л нэг зарчмаар яваад нэг л онилох бодлого гээд байна. Тэгээд үүнтэй холбоотой тэр Гадаадын хөрөнгө оруулалтын банкны талаарх хариултаа нэг товчхон авчихъя.

Ц.Цэрэнпунцаг: Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч М.Оюунчимэг гишүүн асуугаад байгаа гол юм нь мөнгөний бодлого чинь тэгээд ажлын байр бий болгож байгаа юм уу, үгүй юу. Энэ хоёр хоорондоо шууд яаж холбогдоод байгаа юм бэ гэж асуугаад байгаа юм байна гэж ойлголоо. Тийм ээ.

Тэр дээр нь та нэг тодруулаад. Сүүлийн асуулт юу билээ? М.Оюунчимэг гишүүн ээ. Та гүйцээгээд хариулаадах. М.Оюунчимэг гишүүн хариулт хангалтгүй байна гээд байна шүү. 3 Номер.

Б.Лхагвасүрэн: Тийм. Ерөнхийдөө М.Оюунчимэг гишүүн надаас асууж байгаа асуултдаа өөрөө тодорхой хэмжээнд.

Мөнгөний хатуу бодлого явж байгаа учраас угаасаа эдийн засгийг бид

бүр их хүчтэй тэлж ажлын байрыг нэмэгдүүлж чадах ийм мөнгөний бодлого ингэж явуулж чадахгүй байгаа.

Яагаад гэвэл нэгдүгээрт инфляц өндөр байна. Монголбанкны үндсэн зорилго бол инфляцыг шууд өөрийн зорилтот түвшиндээ оруулах байгаа учраас одоо 10 хувь байна гэдэг маань эргээд дахиад 6 хувь руу, 6 нэмэх, хасах 2 хувь руу оруулах. Цаашаа тодорхой хугацаанд энд хатуу мөнгөний бодлого үргэлжлэх зайлшгүй шаардлага байна л гэсэн үг.

Тэгэхээр энэ хүрээндээ ажлын байрыг нэмэгдүүлээд жижиг, дунд үйлдвэрт зориулсан зээлийг гаргах, шууд мөнгөний бодлогоор нэмэгдүүлээд гаргах боломж байхгүй байгаад байгаа юм.

Арилжааны банканд түрүүн Ж.Ганбаатар гишүүнд дурдаж байсан. 6 их наядын үнэт цаас хуримтлагдаад байна. Энэ бол чөлөөтэй эх үүсвэр. Энэ эх үүсвэр гарах боломжтой.

Гэхдээ өнөөдөр бас яагаад гарч чадахгүй байна гэхээр бодлогын хүү өндөр байгаа учраас зээлийн хүү өндөр.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Т.Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Би ганц асуулт тавих гэсэн юм.

Мөнгөний бодлого гээд Монголбанкнаас явуулж байгаа арга хэмжээ төдийлөн хангалттай биш байна гэж миний хувьд боддог. Бодлогын хүүгээ нэмдэг хасдаг өөр бодлогын арга хэмжээ зохион байгуулдаг юм болов уу? Юу зохион байгуулдаг юм бол гээд бодож л байдаг юм л даа.

Тэгээд бид нарын гол ярьж байгаа асуудал бол ерөөсөө л монгол төгрөгийг үнэтэй байлгах, долларыг юу гэдэг юм валютыг их хэмжээгээр оруулж ирэх ийм л асуудлууд байж байгаа шүү дээ.

Тэгээд энэ дээрээ нэлээн сайн анхаарч ажиллаач ээ. Таныг одоо ингээд ярьж байхыг сонсоод байхаар голдуу л энэ жижиг, дунд үйлдвэрлэл гээд л яриад байх юм.

Энэ уул уурхайн бүтээгдэхүүнээ баяжуулах боловсруулах аж үйлдвэрийн ийм бодлогуудаа нэлээн хэрэгжүүлээд, энэ чиглэлээр зээлээ олгож эхлээч ээ. Энэ чиглэлээр арилжааны банкнууддаа чиглэл өгөөд энэ чиглэлийн зээлүүдийг олгохгүй бол наад боловсруулах болон баяжуулах үйлдвэр барьж байгаа компаниуд маань энэ урд хөршөөс тоног төхөөрөмж, техник хэрэгслээ бүгдийг нь зээл дээр авч байна шүү.

Тэгэхээр бидний хоёр дахь үе бол эрдэс баялгаа баяжуулаад, боловсруулаад хоёр дахин үнээр зарж валютын нөөцөө л нэмэгдүүлэх ийм зорилтыг л тавьж явж байгаа шүү дээ.

Тэгээд энэ чиглэлээр зээл олгооч ээ. Арилжааны банкнууд чинь энэ чиглэлээр ер нь зээл олгодоггүй юм байна лээ шүү дээ. Олголоо гэж үзэхэд маш хүндрэлтэй юм билээ.

Би саяхан хэд хоногийн өмнө Төв аймаг дээр томоохон хэмжээний жоншны баяжуулах үйлдвэр дээр очсон. Жилдээ 200 мянгыг үйлдвэрлэх. Тэгээд арилжааны банкууд зээл олгох гэхээр нэг бол валютаар олгодог, нэг хувь хувьцааг чинь авна гэж ярьдаг.

Тэгэхээр таны хэрэгжүүлж байгаа бодлогыг чинь арилжааны банкууд чинь хэрэгжүүлэхгүй байгаа юм биш үү. Арилжааны банкууд чинь албаар юу

гэдэг юм, ингэж валютаар зээл олгож, томоохон үйлдвэр эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудаа сөхрүүлээд эргүүлээд хувь хувьцааг нь авдаг тогтолцоо руу шилжчихсэн юм биш үү гэдэг ийм хардлага төрөөд байгаа юм.

Тийм учраас би таныг мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ аль болохоор жижиг, дунд гэхээсээ илүүтэй томоохон хэмжээний мега төслүүд, Монголд юу гэдэг юм валют оруулж ирэх томоохон хэмжээний эрдэс баялгийн төслүүдээ сайн дэмжиж яваач ээ. Жижиг, дунд чинь дагаад хөгжинө. Дагаад түгжинэ шүү дээ. Тэгээд энэ чиглэлээр ер нь ямар бодлого барьж байгаа юм бэ?

Ер нь хүү өндөр байна, бага хугацаатай байна. Ялангуяа томоохон бүтээн байгуулалт эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд дээр урт хугацаатай зээл өгөх, бага хүүтэй зээл өгөх асуудал дээр л анхаарвал Монгол Улсын эдийн засаг өсөх бололцоо боломж байна.

Бид юу гэдэг юм, нүүрс, төмрийн хүдрээ түүхийгээр нь гаргаад эдийн засгийн хувьд дотоодын нийт бүтээгдэхүүний хувьд өсөж чадахгүй шүү дээ. Дагаад хүн ам өсөж байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10 мянган доллар байж л бид цалингаа нэмж чадна, тэтгэврээ нэмж чадна. Нөгөө багш нарын цалин, нөгөө боловсрол, эрүүл мэнддээ л хөрөнгө оруулж чадна шүү дээ.

Тийм учраас энэ чиглэлээр тодорхой ажлуудыг хийж мөнгөнийхөө бодлогыг чиглүүлээч ээ л гэж хүсмээр байгаа юм. Бусдаар бодлогын хүүг нэмдэг, хасдаг гэдэг асуудал. Тэр бол зах зээлийнх нь зарчмаар л явна. Өөр хэрэгжүүлж байгаа юм алга байна шүү дээ.

Тэгэхээр арилжааны банкнууд, Монголбанк дээр байж байгаа мөнгүүдийг энэ чиглэл рүү л анхаарах тал дээр анхаараад өгвөл их сайн байгаа юм. Тухайлбал, бид нарт ингээд алдаатай юмнууд зөндөө байгаад байгаа байхгүй юу. Өнөөдөр төмөр замаар нүүрсээ гаргах уу, жоншоо гаргах уу гэдэг дээр л бид юм бодох ёстой юм.

Өнөөдөр нүүрсээс хоёр дахин үнээр жоншийг зардаг шүү дээ. Тэгвэл бид жоншоо эхэлж гаргаж байж орж ирэх валютынхаа урсдагийг нэмэгдүүлэх чиглэлээр ч гэдэг юм уу.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг 3 номер. Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Тийм. Ерөнхийдөө аль ч улсын Төв банкны мөнгөний бодлого яг л саяын үнэ тогтворжуулах юм уу, бодлогын хүүгээрээ л хязгаарлагдаж байгаа юм.

Ер нь таны асууж байгаа, ялангуяа тэр боловсруулах үйлдвэр, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг арилжааны банк яагаад гаргаж болдоггүй юм бэ. Энэ рүүгээ илүү төвлөрвөл яасан юм бэ гээд.

М.Оюунчимэг гишүүний асуултад би бас хариулах боломжийг энд давхар хариулаад явчихъя.

Ер нь гаднын банк санхүүгийн байгууллагыг оруулж ирье, ялангуяа хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкиг оруулж ирье гэдэг нь яг л саяын асуултын л гол зорилго л доо.

Тэгэхээр өнөөдөр Монгол Улсын банк, санхүүгийн салбарт 12 арилжааны банк байна. Энэ 12 арилжааны банкны 11

нь хувийн банк, хувийн салбар гэсэн үг. Нэг нь л төрийн өмчтэй Төрийн банк байгаа.

Тэгэхээр энэ утгаараа арилжааны банк нэгэнт л хувийн салбар учраас ямар зорилтот бүлгийг санхүүжүүлж энэ банк санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээ өөрсдөө сонгоод л явдаг.

Түүнээс биш Төв банкнаас тэр зах зээл рүү ажилла, чи энэ салбар луу ор гэж чиглэл өгөх хуулиараа угаасаа хориотой учраас.

Тэгээд ялангуяа өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа энэ 12 арилжааны банк 3.6 сая Монгол Улсын иргэнд л үйлчлэх гээд явж байгаа юм.

Тэгэхээр Монгол Улсыг зах зээл гэдгээрээ яг хүнийх нь тоогоор харах юм бол том зах зээл биш гэдгээрээ гаднын банк, санхүүгийн байгууллага сонирхож орж ирэхгүй байгаа.

Гэхдээ саяын таны хэлж байгаа, ялангуяа уул уурхай, уул уурхайн боловсруулах чиглэл тал руугаа гаднын том том хөрөнгө оруулалтын банкууд сонирхох боломж нь байна л гэж харж байгаа.

Яагаад гэвэл өнөөдөр түүхий эдийн үнэ өндөр байна. Дээр нь бидний гаргаж байгаа экспортын бүтээгдэхүүн дандаа хагас боловсруулсан байгаад байгаа юм. Нүүрс гэхэд л угааж амжилгүй, баяжуулж амжилгүй л гаргаад байгаа учраас. Ялангуяа тэр баяжуулах, таны дурдаж байгаа жоншийг баяжуулж байгаа энэ төсөл рүү ялангуяа тэр хөрөнгө оруулалтын банкууд хөрөнгө оруулалтын зээл өгөх боломжтой.

Тэгэхээр энэ утгаараа ирэх 2024 онд гаднын банк, санхүүгийн салбарыг Монголд илүү таатай нөхцөл бүрдүүлж

байж оруулж ирье гэдэг бодлогыг хийсэн. Тэгээд Монголбанк өөрийнхөө дотоод дүрэм, журмыг өөрчилсөн байгаа.

Дээр нь удахгүй Банк банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тодорхой хөнгөлөлт, гаднын банк сонирхохоор бодлогын зохицуулалтыг оруулж ирэхээр ажиллаж байгаа.

Тэгэхээр ерөнхийдээ 2024 оныг ялангуяа Монгол Улсад гаднын банк, санхүүгийн салбарыг оруулж ирнэ гэдгээр ажиллаж байгаа.

Түүрүүн М.Оюунчимэг гишүүн асуусан дээр **Bank of China**-г оруулах гэж байгаа.

Ер нь Монголд Хятадын 2 банкны төлөөлөгчийн газар байгаа. Нэг нь **Bank of China**, нөгөөдөх нь **ICBC /Industrial and Commercial Bank of China/** гээд Үйлдвэр, худалдааны банк гээд.

Тэгэхээр үүнээс илүү бусад орнуудын банкныг ч гэсэн оруулж ирэхээр. Ер нь зөвхөн нэг улсад зориулсан биш нийтэд, бүгдэд нь зах зээл нээлттэй байхаар зохицуулалтын арга хэмжээ авч байгаа. Тийм.

Тэгээд тэр ч утгаараа гаднын хөрөнгө оруулагчидтай ч гэсэн нэлээн ярьж байгаа. Ялангуяа Оюу Толгойн гүний уурхайн бүтээн байгуулалт бий болоод экспортын хэмжээ нэмэгдэнэ.

Монгол Улсын нүүрсний экспорт ч гэсэн 60 сая тонн хүрээд нэмэгдээд явах юм бол гаднын банк, санхүүгийн байгууллагын сонирхол энэ дээр орж ирэх байх аа гэсэн итгэлтэй байгаа. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: О.Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Уламжлал ёсоор 6 дээр нэмэх, хасах 2 байна гэдэг инфляцын түвшин үндсэндээ 3, 4 дэх жилдээ л орж ирж байна л даа.

Тэгээд гүйцэтгэл нь дандаа хоёр оронтой тоонд гардаг. Тэгээд үүнийхээ шалтгааныг хэлэхдээ КОВИД цар тахал, тээвэр ложистик гэдэг зүйл дээр их тохдог байсан.

Дэлхий нийтээрээ энэ ложистикийн асуудал чинь үндсэндээ шийдэгдээд жил гаран болчихлоо. Гэтэл манай инфляц 20 дахь, 30 дахь сардаа хоёр оронтой тоонд хэвээрээ л яваад байдаг.

Энэ инфляц хоёр оронтой тоогоор ийм удаан хугацаанд явна гэдэг чинь эдийн засаг, тэр тусмаа иргэд, бизнесүүдийн ажил, амьдрал, бүх зүйлийг ямар ч утга учиргүй л болгож байгаа шүү дээ.

Эрх баригчид эдийн засгийн өсөлт яриад байдаг. Нүүрс, зэсийн үнэ яриад байдаг. Яг амьдрал дээр 30 сар хоёр оронтой тоотой инфляц.

Үүний цаана иргэд, бизнесийн амьдралын утга учир гэж ер нь ярих зүйл бараг байхгүй л болж байна. Тэгээд үүний цаад шалтгаан нь юу вэ гэсэн чинь ихэнх талдаа Монголбанканд бүх буруугаа аваад явдаг. Монголбанк нь өөрөө улс төрийн болоод олон талаасаа тайлбараа хийдэггүй л юм шиг санагддаг.

Энэ асуудлын цаад шалтгаан нь яг юун доор байна вэ? Тэгээд үүний цаана бүх юм явсаар байгаад нэг ийм мөнгөний хатуу бодлого гэдэг зүйл рүү очдог. Яг цаад учир шалтгаан нь Монгол Улсын төсөв тэлээд байгаа шүү дээ. Сүүлийн 3, 4 жилд 10 их наядын алдагдалтай төсөв баталдаг. Зөвхөн өнөө жил гэхэд өнгөрсөн жилтэй харьцуулахад 30 хувиар

Монгол Улсын төсөв орж ирж байгаа юм байна. 30 хувиар нэмэгдэж орж ирж байгаа юм байна. Эдийн засаг 30 хувь өссөн билүү?

Тэгэхээр үүний цаана Монголбанканд өөрт нь ямар ч орон зай байхгүй байгаа шүү дээ. Бодлого явуулах ямар ч орон зай байхгүй.

Тэгээд орон зай нь яадаг вэ. Мөнгөний хатуу бодлого явуулдаг. Мөнгөний хатуу бодлого явуулахаар яадаг вэ. Иргэд, бизнесүүдэд мөнгө очдоггүй. Тэр тусмаа бизнесүүдэд мөнгө очихгүй гэдэг нь томоохон аж ахуйн нэгжүүд нь яаж ийгээд нэг санхүүжилтийнхээ асуудлыг шийдээд. Болохгүй бол гаднаас ч гэсэн аваад шийдээд явдаг. Жижиг, дундад нь мөнгө байдаггүй. Хаана мөнгө байна. Төрд мөнгө байна. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд мөнгө байна. Төсөв нь өнөө жил ингээд 30 хувиар өсөж байгаа.

Тэгэхээр үүний цаад учир шалтгаан нь эцсийн эцэст явсаар байгаад Монголбанкандаа ч биш яг энэ төрийн тогтолцоондоо, тэр тусмаа Монголбанканд бодлогоо явуулах тэр хараат бус бие даасан орчин нөхцөл чинь та нарт хуулиар хангагдсан байгаа юм уу гэдэг асуултад тулж очих ёстой байх гэж бодож байна.

Тэгээд л Засгийн газар нь Монголбанк руугаа чигждэг. Өөрөө жилдээ 30, 40 хувиар төсвөө нэмчхээд алдагдлаа 3 жилд хэдэн арван их наядаар нь нэмчхээд орж ирээд та нар мөнгөний ханшаа барьсангүй гэдэг, валютын ханшаа барьсангүй гэдэг. Тэгээд Монголбанк нь өөрөө дуугай суугаад байдаг.

Тэгээд л ерөөсөө тэр Засгийн газар нөгөө талд нь улс төр хийгээд нэг ийм цэвэрхэн яваад байдаг. Бодит байдлыг та

нар бас хэлэх хэрэгтэй шүү дээ. Нэг жил ч гэсэн, сүүлийн жил ч гэсэн энэ их өндөр өсөлттэй үе дээр та нар Засгийн газарт үгүй гэж нэг удаа хэл л дээ.

Энэ чинь буруу. Бид харин бизнесүүдэд тэр бодит сектороо дэмжмээр байна. Төрийг биш. Энэ улс орны чинь эрх чөлөөтэй бизнес эрхэлж байгаа иргэд, бизнесүүд нь авч явдаг юм. Аль эсвэл төр авч явна гээд бид бүр тогтчихсон юм уу аль эсвэл.

Тэгэхээр энэ дээр та нар ямар санаа бодол байдаг юм? Та нарын бие даасан байдал хангагдчихсан юм уу? Та нар мөнгөний хатуу бодлого л гэж байна. Яг үнэндээ Засгийн газарт зөөлөн, иргэд, бизнесүүдэд хатуу гэдэг томьёоллоор л сүүлийн хэдэн жил явж байгаа шүү дээ.

Засгийн газарт бүх зүйл зөөлөн. 30, 40 хувиар төсвөө нэмж болдог. Хэдэн арван их наядаар нь алдагдал тавьж болдог. Бизнесүүдэд 13 хувийн бодлогын хүү, түүн дээр нэмэх нь гээд сая та өөрөө хэлж байна. 18, 20 хувийн жилийн хүүтэй бизнес эрхэлж байдаг. Нөгөө талд нь банкууд нь ашигтай. Ерөөсөө иргэд, бизнес.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: 3 номер.
Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулья.

Б.Лхагвасүрэн: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

Тийм. О.Цогтгэрэл гишүүнтэй ерөнхийдөө санал нэг байгаа. Монголбанканд мөнгөний бодлого явуулах орон зай хязгаартай учраас тэр утгаараа ингээд бодлогын хүү өнөөдөр хатуу түвшинд байна.

Хэрвээ инфляцын түвшин нэг оронтой тоо руугаа энэ оны эцэс рүү ороод, ялангуяа бидний төсөөлж байгаа тэр тооцооллоор ирэх 2024 онд инфляцын

түвшин 6 нэмэх, хасах 2 хувь руу ороод ирэх юм бол бодлогын хүүг жишээлбэл инфляцынхаа түвшиндээ уялдуулаад буулгах орон зай бий болно гэж Төв банкны зүгээс харж байгаа.

Тийм боломж ч байгаа байх гэж төсөөлж байгаа. Ялангуяа та түрүүн бас хэлсэн. Хоёр оронтой тоотой нэлээн олон сар болсон гээд. Тийм. Өнгөрсөн 7 дугаар сард инфляцын түвшин 9.2 хувьтай орж ирэхэд сүүлийн 22 сарын дараа ингээд нэг оронтой тоо руугаа орж байгаа юм.

Тэгэхээр бидний хувьд ямар ч байсан КОВИД, өнгөрсөн оны геополитикийн хурцадмал нөхцөл байдлын тэр хүнд жилийнхээ ард гарсан гэж Төв банкны зүгээс харж байгаа.

Тэр ч утгаараа инфляц нэг оронтой тоо руу ороод явах юм бол бодлогын хүүг энэ дагуу буулгаад явах боломжтой. Зүгээр инфляц өөрөө эргээд түвэгтэй байгаа нь төсвийн тэлэлттэй холбоотой. Тэр ч утгаараа ер нь анх 6 дугаар сард Монголбанк мөнгөний бодлогынхоо шийдвэрийг гаргаад тооцоо, судалгаага олон нийт, хэвлэл мэдээллийнхэнд танилцуулж байхдаа энэ оны эцэст инфляц 8.5 хувьтай гарахаар тооцоо байна гэж ярьж байсан. Дараа нь төсвийн тодотгол орсон.

Тэр утгаараа инфляц эргээд 2 хувиар нэмэгдэх дарамттай байна гэдгээр явж байгаа.

Тэгэхдээ бидний өнөөдрийн тооцоо, судалгаанаас харахад инфляц энэ оны эцэст нэг оронтой тоо руугаа орох боломжтой. Үүнийгээ дагаад явж болно.

Өөр нэг зүйл гэвэл яах вэ бид олон улсын байгууллагуудтай нэлээн ярьж байгаа. Ялангуяа тэр нийлүүлэлтийн сүлжээ гэдгээрээ.

Тэгэхээр ялангуяа мал аж ахуйн гаралтай түүхий эд буюу ургадаг бүтээгдэхүүн гэж хэлдэг ноос, ноолуур, арьс шир, мах гэдэг юм уу. Мөн хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнийг Монгол Улсдаа дотооддоо 100 хувь аваад эргээд экспортод гаргах тал руу нь нэлээн тийм олон улсын байгууллагууд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтраад ногоон зээл хэлбэрээр гаргахаар тооцоо судалгааг хийгээд явж байгаа.

Банкууд ч гэсэн түрүүчээсээ ногоон бондыг гаргаад явж байгаа. Энэ хэлбэрээр явах юм бол хэдийгээр мөнгөний хатуу бодлого байгаа ч гэсэн олон улсын байгууллагаас орж ирж байгаа эх үүсвэрийг илүү их тэр хувийн сектор луу, жижиг, дунд үйлдвэрлэл лүү чиглүүлэх тал руу нь ажиллахаар нэлээн тийм тооцоо судалгааг хийгээд явж байна. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: О.Цогтгэрэл гишүүн нэмж асууя.

О.Цогтгэрэл: Саяын хэлж байгаа тэр үнийн түвшин, валютын ханш гээд цаана нь нэг зүйл бий.

Энэ бүгд чинь төсвийн одоогийн бодлогын нөхцөлд орж ирж байгаа төсөв дээр биелэхгүй шүү дээ. Ер нь.

7 их наядаар төсөв нь тэлчихсэн. Дахиад 2, 3 их наядаар алдагдалтай, 10-аад их наядын тэлэлттэй төсөв орж ирж байдаг. Та нарт угаасаа тийм орон зай байхгүй шүү дээ.

Тийм учраас та нарыг өөрсдийнхөө тэр хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд үгүй гэж эрх баригчдад, Засгийн газарт, гүйцэтгэх засаглалд хэлээч ээ.

Бид нарт бодлого явуулах орон зай алга. Монгол Улсын эдийн засгийг эрүүлжүүлэх орон зай алга гэдгийгээ хэлээч ээ.

Нөгөө талд нь эрх баригчдын бас нэг амлалт бий. Сарын өмнө зээлийн сарын хүүг нэг хувь болгоно гэсэн. Жишээ нь, та магадгүй 2020 онд үүнийг боломжтой л гээд та ярьж байсан.

Одоо ирэх жил нөгөө мөрийн хөтөлбөрийн биелэлтийн хугацаа дуусаж байна. Ирэх жил Монгол Улс дахь зээлийн хүү сарын 1 хувь болох боломжтой юу?

Ц.Цэрэнпунцаг: 3 номер хариулъя.

Б.Лхагвасүрэн: Өнөөдөр арилжааны банкны дундаж зээлийн хүү 16.4 хувьтай байгаа.

Ер нь 2024 ондоо сарын 1 хувийн хүүд орох боломж байхгүй. Яагаад гэвэл бодлогын хүү өнөөдөр ингээд 13 хувьтай явж байгаа учраас энэ нь өөрөө зүгээр сарын хүүд шилжүүлэхэд л 12 гэдгээр бодох юм бол 12 хувиас өндөр ийм суурь хүү байна гэдэг маань 2024 ондоо 1 хувь руу л орох боломж байхгүй.

Гэхдээ бидний хувьд 2024 онд инфляцыг онилсон 6 нэмэх, хасах 2 хувь руугаа орох боломжтой гэдэг тооцоо судалгаа байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд асуултаа асууя.

Ч.Хүрэлбаатар: Надад Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгчөөс буюу Монголбанкнаас янз бүрийн асуулт алга.

Харин бодлогын талаараа ер нь нэлээд ойлгомжтой зүйлийг хэдүүлээ Эдийн засгийн байнгын хороон дээрээ

ярьж ойлголцох нь зөв болов уу гэж бодож би зүгээр санал хэлж байгаа юм шүү.

Одоо ингээд дэлхий нийтийг аваад үзэх юм бол инфляцыг бууруулна гээд улс орнууд ер нь бодлогын хүүгээ бууруулах тийм хандлага ажиглагдахгүй байгаа.

Европт нэмсэн. Америк сая нэмнэ нэмнэ гэж ярьж ярьж байгаад хэвээр нь тогтоогоод явчихлаа.

Тэгэхээр яг ийм нөхцөл байдалд Монголбанк бодлогын хүүгээ буулгах тийм орон зай байхгүй байгаа юм. Хэрвээ буулгавал төгрөгийн ханш унаж эхэлнэ. Бодлогын хүүгийн хамгийн эхний нөлөө нь төгрөгийн ханш дээрээ илэрч гарч ирнэ.

Тийм учраас бодлогын хүүг буулгах орон зай байхгүй байгаа үед Монголбанк одоо яг юу хийх ёстой вэ гэдэг ийм л зүйл байгаа юм.

Тэгэхээр энэ дээрээс би удаа дараа олон удаа ярьж байгаа нэг л зүйл байгаа. Монгол Улсын хувьд ингээд санхүүгийн салбар яах вэ гаднаас хөрөнгө оруулалт орж ирж байгаа. Тэр нь нэлээд саарчихсан ийм байгаа үед гаднын банкныг оруулж ирэх ёстой юм.

Энэ дээр Монголбанк нэлээд санал санаачилгатай ажилламаар байна. Монголбанкныхан маань ерөөндөө суугаад над дээр хэн орж ирэх бол гээд суугаад байвал хэн ч орж ирэхгүй.

Өөрсдөө идэвхтэй явж тэр банк, санхүүгийн салбарынхантай нь уулзаж учирч, бодлогоо тайлбарлаж байж энэ Монгол Улсад гаднын банкнууд орж ирж үйл ажиллагаа явуулна.

Тэгвэл харин бодитойгоор энэ инфляц буух, төгрөгийн ханш чангарах, цаана нь дагаад үйлдвэрлэл, үйлчилгээ өсөх, хүү буух ийм л үр дүнд хүрэх юм.

Гаднын банкиг Монголд оруулж ирэх шаардлагатай гэхээр манайхан зарим нь эсэргүүцээд байдаг л даа. Тэгсэн мөртлөө нөгөө талдаа хүү өндөр байна гээд зовлон яриад байдаг, зээл олдохгүй байна гээд байдаг. Тэгвэл яг өнөөгийн нөхцөл байдалд бодлогынх нь хүрээнд ямар зүйлийг бид хийж хэрэгжүүлэх ёстой вэ гэвэл ерөөсөө л хамгийн хурдан гарц бөгөөд үр дүнгээ авчрах зүйл бол гаднын банкиг Монголд оруулж ирэх энэ л зүйл байгаа байхгүй юу.

Тийм учраас бодлогын бичиг баримт дээр гаднын банкиг оруулж ирнэ гээд л биччихсэн байна. Маш зүйтэй. Гэхдээ үүнийг яаж хийх вэ гэдэг нь Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө, их чухал шүү.

Та бүгд гарч ажиллаж, уулзаж учирч, юмаа тайлбарлаж явах ёстой. Хаалгаа цоожлоод, цонхоо хаачаад өрөөндөө суугаад байгаад байвал хүн орж ирэхгүй шүү дээ.

Тэгээд дээр нь энд өнөөдөр Монголд үйл ажиллагаагаа явуулж байгаа банкууд ч гэсэн гаднын банк оруулж ирэхийг хүсэхгүй байгаа.

Өөрсдийнхөө ашгаа бодно, орлогоо бодно. Гэтэл бидний хувьд энэ хүүг буулгах ёстой, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх ёстой. Төгрөгийн ханш маань байгаа нөхцөл байдалдаа чангараад явах ёстой зэрэг ийм зүйл дээрээ бид илүү анхаарал тавих ёстой.

Тэгэхээр Монголбанк дээр илүү их санал санаачилгатай ажиллаач ээ гэдгийг би хэлмээр байна.

Дээр нь өөрийг чинь өнөөдөр хэлчих болов уу гээд хараад байсан. Хэлсэнгүй. Монгол Улсын валютын нөөц 4 тэрбум 124 сая долларт хүрч өссөн байгаа. Энэ нь манай санхүүгийн салбарт төгрөгийн ханш тогтворжих ийм гол боллоцоог хангаж ажилласан. Монголбанк энэ чиглэл дээр сүүлийн саруудад сайн ажиллаж байгаа гэдгийг би хэлмээр байна.

Ц.Цэрэнпунцаг: Ч.Хүрэлбаатар сайд ерөнхийдөө санал хэлчихлээ.

Ингээд хариулах шаардлагагүй учраас Ч.Ундрам гишүүн та асуултаа асууя.

Ч.Ундрам: Ерөнхийдөө бусад гишүүд ихэнх асуултуудыг асуучихлаа л даа.

Одоо манай Төв банкны үндсэн зорилго чинь үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг тогтвортой байлгах шүү дээ. Тэгээд 2023 оны мөнгөний бодлого нэг оронтой тоонд барина гээд.

Тэгээд түрүүчийн сар нэг оронтой тоонд ороод энэ сар 10 хувьтай болсон. Инфляц гэж хэлж байна л даа. Тэгээд ер нь 2023 оны энэ инфляцын дунджийг нь харах юм бол хоёр оронтой тоондоо л байгаа.

Тэгэхээр 2023 оны мөнгөний бодлогын зорилтууд чинь хүрэхгүй. Энэ жил хүрэхгүй байгаа. Тэгээд ирэх жил 6 дээр нэмэх, хасах 2 гэхээр бас хүрэх юм уу, үгүй юу? Би итгэл үнэмшил алга.

Төсвийн бодлого тэлж байгаа. Үүнийг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгэхээр 2024 онд бодлогын хүүг нэмэх үү, үгүй юу гэдэг нэг ийм асуулт байгаад байна.

Хоёрт, би Ч.Хүрэлбаатар сайдтай санал нэг байна. Гаднын банкуудыг бид оруулж ирэх ёстой.

Гэхдээ яг одоо орж ирэхээр санал тавиад, яриа хэлэлцээр, сонирхоод явж байгаа тийм банкууд байгаа юу? Хууль, эрх зүйн орчны хувьд бид илүү сайжруулах шаардлага үүсэж байгаа юу гэдгийг мэдмээр байна.

Хоёрдугаарт, орон нутгаас сонгогдсон гишүүдийн хамгийн гол асуудал бол ипотекийн зээл байгаа. Бүгд л асууж байгаа. Хотоос хөдөө рүү чиглэсэн Засгийн газрын бодлоготой холбоотой ипотекийн зээл ерөөсөө гарахгүй байна гээд хэлж байна.

Тэгээд 2023 онд мөнгөний бодлогыг бид хэлэлцэж байхад би бас танаас асууж байсан. Засгийн газар луу яг шилжүүлэх үү, шилжүүлж чадах уу гээд.

Тэгээд шилжүүлнэ гээд баталсан. Засгийн газар луу ипотекийн зээлээ шилжүүлж чадаагүй өнөөдөр 10 сар болж байна шүү дээ. Засгийн газар чинь авч чадахгүй юм чинь угаасаа.

Тэгэхээр одоо энэ 2024 онд хэдүүлээ ипотекийн зээлээ яах юм? Засгийн газар орон нутагт 150 сая хүртэлх үнийн дүнтэй орон байр худалдаж авах юм бол 6 хувийн хүүтэй зээл олгоно. Хотоос хөдөө рүү шилж ээ, та нар хөдөө сайхан амьдар гээд байдаг. Тэгээд яг очоод байр авъя гэхээр ипотекийн зээл гарахгүй байна л даа.

Тэгээд Төв банкны хуулиар энэ чинь хориотой. Тийм ээ. Хориглочихсон. Болохгүй.

Тэгэхээр яг энэ дээр ямар бодлого барих вэ? Мэдээж инфляцыг өсгөмөөргүй байна. Гэхдээ орон нутаг руу чиглэсэн ийм ипотекийн зээл байвал бас арай өөр

үр дүн гарч магадгүй гэж би бодоод байна.

Тэгээд инфляцад нөлөөлж байгаа хамгийн сөрөг хүчин зүйл бол энэ төсвийн тэлсэн бодлого байгаа. Энэ дээр нэмээд мэдээж яг энэ үнэд нь нөлөөлж байгаа тээврийн үнэ. Энэ 9 сард сургалтын төлбөр нэлээн нөлөөлсөн гэж би харж байгаа.

Тэгэхээр яг иймэрхүү юмнууд руугаа чиглэсэн энэ үнэд дам нөлөөлөөд байгаа асуудлууд. Тийм ээ. Шатахуун, импортыг орлуулах бүтээгдэхүүнийг дэмжих ч гэдэг юм уу, иймэрхүү чиглэлийн юмнууд ер нь энэ мөнгөний бодлого дээр хэр тусгагдаж явж байгаа вэ?

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг 3 номер. Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө инфляц сарынхаа тоогоор оны төгсгөл рүү нэг оронтой тоогоороо орох боломжтой гэдэг манай тооцоо, судалгаа байгаа юм. Гэхдээ мэдээж таны хэлж байгаа төсөв ингэж их тэлж байгаа нөхцөлд биелэх боломж нь юу байна гэж байгаа юм.

Тэгэхээр нэгэнт л төсвийн тэлэлттэй үед инфляцынхаа зорилтот түвшинд хүргэхийн тулд мөнгөний бодлого яг л тэр лүүгээ чиглэсэн л арга хэмжээ авч явна.

Тэгэхээр энэ мөнгөний бодлогын хатуу төлөв өнөөдрийг хүртэл ингээд үргэлжлээд л явж байна. 13 хувь дээрээ.

Хэрвээ ирэх жилийн төсвийн тэлэлтээрээ инфляц өөрөө зорилтот түвшин рүү орохгүй л байх юм бол хатуу

төлөв хувиараа үргэлжилнэ. Бүр хатууруулах ч тал руугаа ч алхах боломжтой.

Тэгэхээр хүү дээшээ ч явах боломжтой, доошоо ч буурах боломжтой.

Тэгэхээр энэ бүгдийг л бид тооцоолоод явж байгаа.

Ер нь сүүлийнх нь асуултыг нь бас эхнийх нь асуулттай нь хамт яах юм бол өнөөдрийн энэ 10 хувь байгаа инфляцын дийлэнх хэсэг нь нийлүүлэлтийн шинжтэй. Яах вэ, сүүлд төсвийн тодотголоор эдийн засаг нэлээн идэвхжиж ирж байгаа, эрэлтийн шинж гарч байгаа. Тэр утгаараа л бид мөнгөний бодлогыг хатуу байлгаад байгаа юм.

Тэгэхээр ирэх онд хэрвээ нийлүүлэлтийн шинжтэй инфляц нь тээвэр ложистикийн асуудлууд хямдраад, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ хэвийн хэмжээнд нь олгогдоод явах юм бол нийлүүлэлтийнх нь нөлөө нь багасаж ирэх учраас бидний хувьд боломжтой л гэж харж байгаа юм.

Зүгээр төсвөөрөө дамжаад эрэлт өөрөө нэмэгдээд эхлэх юм бол тэгээд л мөнгөний бодлогыг хатууруулахаас өөр орон зай, өөр сонголт байхгүй л болох байгаа юм.

Гаднын банкны хүсэлт одоо аль нэг банкаас ирээгүй байна.

Гэхдээ гишүүдийн ярьж байгаа, Ч.Хүрэлбаатар сайдын таны хэлж байгаа ер нь гаднын банкиг оруулж ирэх талаар бид нэлээн идэвхтэй ажиллаад явж байгаа.

Банкуудтай уулзахад 3.6 сая хүн амтай энэ зах зээлийг жижигхэн зах зээл. Тэгээд 12 арилжааны банк иргэдэд үйлчлээд явж байгаа учраас бидний хувьд

орон зай байхгүй юм шиг байна гэж хараад байгаа хэдий ч ялангуяа тэр уул уурхайн боловсруулах салбар, томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалттай хэсэг дээр цаашдаа хийгдээд явна гэдэг утгаар гаднын томоохон банк, ялангуяа хөрөнгө оруулалтын чиглэлийн банкнууд орж ирэх, ажиллах боломж нь бүрэн байна гэдгээрээ бид тайлбар, танилцуулга хийгээд явж байгаа.

Ипотекийн зээлийн хувьд яах вэ, хэдийгээр Монголбанк өнөөдөр Засгийн газарт шилжүүлж чадахгүй байгаа учраас энэ хөтөлбөрөөс бүрэн гарч чадахгүй байгаа.

Нэгдүгээрт, үүнийг хэн авч явах юм гэдэг нь тодорхой бус байгаа.

Хоёрдугаарт, Монголбанк өнөөдрийг хүртэл 2013 оноос хойш ингээд 10 жил энэ хөтөлбөрийг авч явахдаа өөрийн эх үүсвэрээс 3.6 их наядыг санхүүжүүлчихсэн байгаа учраас энэ эх үүсвэрээ өөрөө буцааж олж авах ёстой. Энэ хариуцлага манайд байж байгаа учраас энэ хөтөлбөр дотроо ингээд байж байна.

Нийт эргэн төлөлт дээрээ 350 тэрбум төгрөг жилдээ хуримтлагдаж орж ирж байгаа учраас одоо үүнээс хойш явж байгаа, ялангуяа 09 сарын 01-нээс хойш энэ ипотекийн хөтөлбөр эргээд хэвийн байдалдаа орж байгаа нь эргэн төлөлт дээрээ эргээд санхүүжилт нь ороод явж байгаа.

Нэг зээлдэгчийн ипотекийн зээлийн 80 хувийг нь Монголбанк, 20 хувийг нь арилжааны банк өөрөө гаргаад явдаг. Тэр утгаараа банк эх үүсвэрээ өөрөө нэмээд олгоод явж байгаа учраас хэвийн байдалдаа орох бүрэн боломж нь байна гэж Монголбанкны зүгээс харж байгаа.

Дээр нь Засгийн газрын тэр “Шинэ хөдөө” Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ялангуяа орон нутагт илүү их орон сууцын ипотекийн зээлийг гаргая гэдгээрээ энэ оныг дуустал дийлэнх эх үүсвэр илүү орон нутаг руу чиглэж гарна гэсэн ийм байр суурьтай байна.

Ц.Цэрэнпунцаг: Т.Доржханд гишүүн байхгүй учраас Б.Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Монголын эдийн засагт макро түвшинд өөрчлөлтүүд гарч байгаа. Энэ өөрчлөлт нүүрс дээр хийсэн менежментийн үр дүнд гарч ирж байгаа гэж.

Түүнээс биш бид нэг их мундаг юм хийгээд, бодлого боловсруулаад гайхалтай юм хийчихсэн юм байхгүй шүү дээ. Үүнийг хэлэх ёстой.

Банкны системд хоёр сайн өөрчлөлт гарсан. Нэгдүгээрт, гадаад валютын нөөц 4.1 тэрбум доллар болсон.

Хоёрдугаарт нь, монопол байсан арилжааны банкууд дээр IPO хийж 5 банкн дээр 5-аас 10 хувийг нь арилжихад нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 320-иод мянга, дүрмийн сан нь 470 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ийм сайн үзүүлэлт байгаа юм.

Тэгэхдээ энэ бол 12 сарын 31-ний дотор хийх ёстой ажлууд байгаа шүү дээ. Энэ хуулиар хийсэн үүрэг. Үүнийг та нар юу гэж харж байна аа? Цаашдаа ер нь энэ банкны нэг хувьцаа эзэмших 20 хувиас хэтрэхгүй байх гэсэн энэ зорилтууд маань хэзээ биелэгдэх вэ? Энэ эхний асуулт.

Хоёрдугаарт нь, 2024 оны төсвийн төсөл бидний гар дээр ирээгүй байна.

Зүгээр миний олж мэдсэнээр нэлээн өөдрөг төсөв явж байгаа бололтой.

Нүүрсийг 60 сая тонн, төмрийн хүдэр 8.4 сая тонн, зэс 1.5 сая тонн, нүүрс 60 сая тонн гээд. Эдийн засгийн өсөлт 7 хувь. Төсвийн орлого 27 тэрбум төгрөг гээд.

Ингээд бодохоор дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 80-аад их наяд орчим болох нь л дээ. Үүнтэйгээ хэр зэрэг уялдаж байна?

Хоёр дахь асуулт. Энэ дээр ямар эрсдэлүүд байна? Одоо та нарын оруулж ирсэн мөнгөний бодлоготой харшлах эрсдэлүүд юу байна? Үүнийг хэлээч гэсэн ийм юм байгаа.

Дараагийн асуудал юу гэхээр Монголын энэ аж ахуйн нэгжүүд урт хугацаатай, бага хүүтэй зээл хэрэгтэй байна. Бид хэрэгтэй хэрэггүй янз бүрийн худаг ус гаргана, бодлого боловсруулна гээд маш их хэмжээний зээл авах юм.

Энэ зээлүүд маань үр ашиггүй зүйлд зарцуулагдаад байгаа юм. Өнөөдөр жижиг, дунд үйлдвэрлэл болно. Сая Т.Энхтүвшиний хэлж байгаа тэр нэмүү өртөг шингээх, ашигт малтмалыг боловсруулах энэ чиглэлд бага хүүтэй, урт хугацаатай зээл хэрэгтэй.

Сая 25 жилийн хугацаатай, жилийн 2 хувийн хүүтэй зээл шийдлээ шүү дээ. Хөдөө аж ахуйд. Ийм зээлийг аваад бага хүүтэйгээр дамжуулж өгөх ийм боломжууд ер нь юу байдаг юм бэ? Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө. Үүнийг хэлж өгөөч гэсэнд ийм асуулт байна.

Дараагийн асуудал, танай Санхүүгийн мэдээллийн алба байх аа. Нэг ийм байгууллага байдаг. Сүртэй сүртэй мэдэгдэл хийдэг. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

тогтолцоо олон улсын түвшинд хүрлээ гээд л.

Монгол шиг 16, 17 тэрбум долларын эдийн засагтай болсон нь их мундаг. Терроризмыг санхүүжүүлээд байгаа юм байхгүй л дээ. Мөнгө угаалт асар их байгаа шүү дээ. Мөнгө угаалт замбараагүй байгаа шүү дээ.

Ерөнхий сайд хэлсэн. Дотоодын нийт бүтээгдэхүүнтэй тэнцэх хэмжээний мөнгө угаалт байгаа гэж байгаа шүү дээ.

Тэгээд үүнийг хаанаас нь хардаг юм бол оо? 40 зөвлөмжийг бүгдийг нь биелүүлчихсэн гээд. Маш их хэмжээний сэжигтэй гүйлгээ байгаа шүү дээ. Үүнийг та нар хянадаг юм уу? Та томилдог. Энэ албаны даргыг. Энэ мэдээллүүдийг ер нь олон нийт мэдэж болох уу?

Надад тоо баримтууд байна. Тэгээд их мундаг. Зөвлөмжийг бүгдийг нь биелүүлээд байдаг. Зүгээр сайн л даа. Монгол ФАТФ-ын зөвлөмжүүдийг бүгдийг нь биелүүлсэн. Тэгэхдээ өрөөсгөл яваад байх шиг санагдаад байх юм.

Тэгэхээр энэ дээр энэ байгууллагын үйл ажиллагаатай.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Хариулт. Ажлын хэсгийн 3 номер. Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулья.

Тийм. Ерөнхийдөө сая өргөн барьсан улсын 2024 оны төсвийн төсөлтэй танилцсан.

Дотоодын нийт бүтээгдэхүүн 70 их наяд, инфляцын түвшин 8.5 хувьтай байна, төлбөрийн тэнцлийн ашигтай

байна гэдгээрээ 60 сая тонн нүүрс экспортлох гээд л бүх тооцоо, мэдээллийг Монголбанк авсан байгаа.

Би түрүүн гишүүний асуултад хариулахдаа хэлж байсан. Монголбанкны өөрийн төсөөлөл арай даруухан гэдэг юм уу, үүнээс арай багаар байгаа. Жишээлбэл, нүүрсийг энэ оны л гүйцэтгэлээр. Одоо бол 51 сая гэдгээрээ 51 юм уу, 50 сая тоннд л байх болов уу гэдгээр төсөөллөө авчихсан.

Ялангуяа ирэх оны гадаад эдийн засгийн төлөв байдал, ялангуяа геополитикийн буюу олон улсын хувьсгалмал нөхцөл байдал өөрөө манай гол худалдан авагч урд хөршид яаж нөлөөлөх вэ, тэр нь өөрөө нүүрсний үнэ болон зэсийн үнэд яаж нөлөөлөх вэ гэдгээрээ тооцоод судалгаагаа хийгээд Төв банкны зүгээс нэлээн тийм өөдрөг бишээр энэ төсөөллүүдээ хийсэн л дээ.

Тэгэхдээ яах вэ, инфляцын түвшин, бусад гол гол параметр, гол гол үзүүлэлтүүд нь ерөнхийдөө ойролцоо байгаа учраас ингээд байж байгаа юм.

Тэгээд би бас түрүүн Ч.Ундрам гишүүний асуултад хариулахдаа төсөвтэй уялдуулаад мөнгөний бодлого өөрөө яах вэ гэхээр одоо бас л яг л хэрвээ төсвийн тэлэлт өөрөө эдийн засгийг өдөөгөөд инфляцыг өдөөх юм бол мөнгөний бодлого хатуурахаас өөр зам байхгүй учраас бодлогынхоо хувьд яг л тэгээд л явна.

Тэгээд хуулиар бол ерөөсөө Монголбанкны үндсэн зорилго ойлгомжтой. Инфляцын түвшин зорилтот түвшиндээ авчрах учраас. Түүндээ таарсан хатуу бол хатуу мөнгөний бодлогыг л явуулахаар л ингэж төсөөлөл хийгдээд ингэж л нөгөө нийцтэй байдлаа энэ талаас нь ингээд хараад явж байгаа юм.

Санхүүгийн мэдээллийн албаны хувьд яах вэ та бүхэн сайн мэдэж байгаа. 2019 онд Монгол Улс Олон улсын мөнгө угаах, терроризмтой тэмцэх байгууллагын саарал жагсаалтад ороод жилийн дотор маш хурдан хугацаанд энэ жагсаалтаасаа гарсан.

Тухайн үед 2019 онд саарал жагсаалтад ороход тэр Олон улсын мөнгө угаах, терроризмтой тэмцэх байгууллагын 40 зөвлөмжийн 20-ийг нь, талыг нь ч хүртэл биелүүлж чаддаггүй байсан бол одоо үүнээс хойш 40 зөвлөмжийн 40-ийг нь бүрэн болон давуу байдлаар хангасан гэдэг улс болж байгаа юм. Тэгээд Ази тивдээ анхны улс болоод явж байгаа.

Тэгэхээр нэгэнт анх нөгөө саарал жагсаалтад орсон тэр муу туршлага, сургамжаасаа аваад ингээд ажиллаад явж байгаа.

Санхүүгийн мэдээллийн алба өөрөө банкнаас мэдээлэл авдаг. Мөн банк бус санхүүгийн байгууллагуудаас мэдээлэл авдаг. Банк болон банк бус санхүүгийн байгууллагаас энэ хийгдэж байгаа гэрээ, хэлэлцээр ч юм уу, төлбөр тооцоо нэгэнт сэжигтэй юм шиг байна гэдгээр мэдээлэл Монголбанк өөр дээрээ аваад тэр харилцагчийг нь танай харилцагч мөн үү, биш үү, хэдэн удаа ийм гүйлгээ хийгдэж байгаа вэ, анх удаагаа хийгдэж байгаа бол мэдээж сэжигтэй.

Олон удаагийн давтамжтай хэвийн бизнесийн үйл ажиллагаа бол хэвийн байна гэдгээрээ ингээд явдаг. Тэгээд сэжигтэй гэсэн мэдээллийг цааш нь хууль хяналтын байгууллагад өгөөд явдаг байгаа.

Тэгэхээр хууль хяналтын байгууллага үүнийг нь цааш нь судлаад

үнэхээр мөнгө угаах, терроризмтой тэнцэх байгууллагын тэр үнэхээр мөнгө угааж байгаа гүйлгээ байна уу, хууль бус гүйлгээ байна уу гэдгийг нь шалгаад явдаг юм.

Тэгээд тэр утгаараа энэ мэдээллийг цааш нь хууль хяналтын л байгууллагад өгдөг. Түүнээс өөрөө үүнийг олон нийтэд зарлаад ч гэдэг юм уу, өөрөө тийм хууль хяналтын байгууллагын үүргийг давхар гүйцэтгэх эрхгүй ийм байгууллага. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: Б.Баттөмөр гишүүн нэмж асуулт асууя. 1 минут.

Б.Баттөмөр: Бизнес эрхлэгчид бага хүүтэй, урт хугацаатай зээл олгох чиглэлд хариулчхаарай.

Дараагийн асуудал юу гэхээр энэ валютын нөөцийг бүрдүүлдэг гол бүтээгдэхүүний нэг энэ алт байгаа шүү дээ. Тийм ээ. Оюу Толгойн тэр баяжмал дахь алтны хэмжээ их хэмжээгээр нэмэгдэж байгаа, агуулга нь их нэмэгдэж байгаа юм. Жилд 300-аад сая доллар орчмын алтыг Оюу Толгойгоос авдаг гэж байсан. 2024 онд энэ төсөөлөл, энэ тооцоо ер нь ямархуу байдалтай байна. Үүнийг хэлж өгөөч ээ гэж ийм хоёр асуулт байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер нэмж хариулья.

Б.Лхагвасүрэн: Б.Баттөмөр гишүүний асуултад нэмж хариулья.

Тэгэхээр бизнес эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгох энэ асуудлыг улсын төсөвтэй бас уялдуулаад явж байгаа. Улсын төсөв дотор хүүгийн хөнгөлөлт буюу дотаци сууж өгч байгаа.

Түрүүн А.Энхжин захирал хариултдаа ипотекийн зээлтэй холбоотой

ялангуяа орон нутагт олгох ипотекийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийн тоо хэмжээ хэлсэн.

Энэ оны хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хувьсгал, хүнсний аюулгүй байдлын хүрээнд 200-аад тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлт дотаци орчихсон байсан.

Тэр утгаараа арилжааны банканд чөлөөтэй байсан эх үүсвэр 400-аад тэрбум төгрөгийг ялангуяа энэ хүнсний ногоо тарьж байгаа, газар тариалан эрхэлж байгаа газар тариалангийн аж ахуйн нэгжүүдэд олгосон. Тэр ч утгаараа үр дүн нь гарч байх шиг байна. Ялангуяа улаан буудайгаараа Монгол Улс 100 хувь, төмсөөр 100 хувь өөрийгөө бүрэн хангах, ялангуяа хүнсний ногоогоороо 85, 86 хувь.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Та тодруулж асуух уу, болсон уу? Тодруулж асууя. Б.Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ яах вэ, тэр Хүнсний хувьсгалтай холбоотой, ипотекой холбоотой. Яг үйлдвэрлэл явуулж байгаа. Өөрөөр хэлбэл сая тэр Т.Энхтүвшин гишүүний яриад байгаа одоо нөгөө ашигт малтмалд нэмүү өртөг шингээдэг, нүүрсийг угаадаг ч юм уу, баяжуулдаг ч юм уу энэ үйлдвэрүүдэд тэр 2 хувийн хүүтэй, 25 жилийн хугацаатай зээлийг олж ирээд 3 хувийн хүүтэй ч юм уу ингээд тэр валютаар нь олгодог ийм зүйлийг л хүсээд байна л даа.

Тэр яах вэ тэр ипотект болгож байгаа, нөгөө хүнсний хувьсгалд өгч байгаа. Тэрийг дэмжиж байгаа. Яг бодит үйлдвэрлэлд, энэ эдийн засгийнхаа есөлтийг бий болгодог, ажлын байр бий болгодог энд гэж байгаа.

Төгсгөлд нь нэг асуулт байгаа. Тэр финтек үйлчилгээний компаниудад нэг зөвшөөрөл олгосон. Тийм биз дээ. Тийм ээ. Тэрний ирээдүй, тэр ер нь ямархуу хэмжээнд явж байна аа? Тэр дээр нэг хариулт өгөөдөхөөч. 10 газарт өгсөн байдаг. Тийм ээ.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг. 3 номероор нэмж хариулъя. Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Би бас түрүүн Б.Баттөмөр гишүүний нэг асуултад дутуу хариулсан.

Оюу Толгойтой бидний хувьд уулзалт, яриа хэлэлцээ хийж байгаа. Тэр нь нөгөө зэсийн баяжмалтайгаа цуг гараа явж байгаа алтны хэмжээг. Тэгээд ерөнхийдөө энэ 2024 онд 5.5 тонн гэсэн ийм тооцоо, судалгаа байгаа. Энэ 2023 оных нь хоёулаа ижилхэн. 5.5 тонн л гэж байгаа.

Тэгэхээр үүнийг эргээд алт хэлбэрээр нь улсын нөөцөд оруулах тодорхой хэмжээний саналуудыг яриад явж байгаа.

Тэгээд тэр нь болчих болов уу? Сүүлийн асуулт нь, ялангуяа финтек, тэр цахим хөгжлийн юун дээр Монголбанк нэлээн нээлттэй байгаа. Тэгээд ялангуяа финтек компаниудад шууд харилцагчаа таньж мэдээд өөрөө шууд автоматаар утсаар бол утсаар, цахимаар зээлээ олгочихдог тэр процесс нэлээн идэвхжиж байгаа.

Ялангуяа сүүлийн үед тэр банк бус санхүүгийн байгууллагын зээлийн.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээгээд 1 минут өгчихье. Гүйцээгээд хариулчих. 3 номер.

Б.Лхагвасүрэн: Ялангуяа заавал банкн дээр очиж зээл авахгүйгээр өөрөө хаа байгаа газраасаа шууд зээлд хамрагддаг энэ салбар нэлээн хөгжиж байгаа.

Тэгээд яах вэ, нийт зээлийн дүн нь их том биш. Жижиг зээлээр явж байгаа.

Тэгээд Монголбанкны зүгээс хамгийн гол нь бид хэд дэд бүтцийнх нь холболтыг сайн хийж өгч байгаа. Яагаад гэвэл тэр компанийн төлбөр тооцоо нь өөрөө банкаар явах учраас банкныхаа банк хоорондын сүлжээ рүү тухайн аж ахуйн нэгжүүдийг холбож өгөөд дэмжээд явж байгаа учраас энэ цаашаа улам өргөжих байх л гэж харж байгаа. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: Ингээд гишүүд асуулт асууж дууслаа.

Би нэг товчхон тодруулсан маягтай нэг асуулт асуучихъя. Б.Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө.

Та нар одоо ингээд яах вэ дээ энэ авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэр дунд чинь яах вэ бодит практик амьдралд яг хэрэгтэй. Өнөөдөр бас нэг жижиг жижгээрээ сайжруулаад яваад байхад үр дүн нь том гараад ирэхээр нь ганц нэг шийдлүүд түрүүн ярилаа л даа.

Ногоон бонд, ногоон санхүүжилт гээд яриад байна. Тийм ээ.

Тэрийг та хариулахдаа жишээлбэл энэ мөнгөний хатуу бодлого чинь жижиг, дунд бизнесүүдийг хүнд тусаад байна гэхээр зэрэг тэдэнд эх үүсвэр бол энэ ногоон санхүүжилт гэдэг юмаар гарч ирж байгаа гэсэн. Үүнийгээ яг нарийн нэг жоохон тайлбарлаад өг. За юу. Ийм ийм механизм, ийм системээр явж ингэж шийдэж байгаа юм гээд. Тодорхой хариулаарай. Энэ дээр нэг хариулт.

Хоёрдугаарт, бид нарын энэ инфляцид гол нөлөөлдөг том нөлөө бол ханшийн нөлөө орж ирж байгаа. Тэгээд ханш дээр хамгийн гол нь та нар түрүүн хэлсэн нийлүүлэлтийнхээ сүлжээ талаасаа бид ажиллаж байгаа гэж. Энэ дээр яг ямар ажил хийж байгаа юм? Энэ хоёрт тодорхой сайн хариулаад өгөөрэй. 3 номер хариулья.

Б.Лхагвасүрэн: Ц.Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулья.

Тийм. Ногоон зээл бол одоо бид ер нь банк, санхүүгийн байгууллагуудын олгож байгаа энэ зээлийг энэ ногоон зээл ногоон биш зээл гэж ялгаж салгах тэр тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг тогтоож өгсөн. Таксономи гээд. Тэр утгаараа өнөөдөр ингээд яг таксономийнхоо дагуу шалгаад үзэхээр энэ нийт тийн олгосон зээлийн 2-хон хувь нь л ногоон зээл байгаад байгаа юм.

Тэгэхээр одоо энэ ногоон зээлийг цааш нь идэвхжүүлэх нь өөрөө энэ олон улсын, ялангуяа тэр Парисын хэлэлцээр гээд энэ дэлхий нийтийн хандлага болсон учраас үүнийг бүр 10 хувьд хүргэх ийм зорилт тавьсан.

Тэгээд хамгийн гол нь ногоон зээл гэдгээ өөрөө тодорхойлж гаргах, тэрийг тайлагнах, тэгээд тайланг нь аваад баталгаажуулах. Тэгээд дараа нь цаашаа олон улсад тайлагнах асуудал нь хамгийн чухал байгаад байгаа юм.

Тэгэхээр ерөнхийдөө энэ оны хувьд Европын Сэргээн Босголт Хөгжлийн банк ялангуяа ХААН, Хас банкаар дамжуулаад энэ ногоон зээлийн эх үүсвэр өгсөн. Нийт дүн нь бараг жижин, дунд үйлдвэртэйгээ хамтруулаад үзэх юм бол 300 сая доллар орж ирсэн.

Тэгэхээр энэ эх үүсвэрийг ашиглаад өгч байгаад эргээд үүнийгээ

ногоон зээлд олгосон гэдгээ тайлагнах ёстой юм.

Тэгэхээр энэ тайлагнал өөрөө яг өнөөдөр Монгол Улсад бас стандарт байхгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ утгаараа Монголбанк дээр **“Их өгөгдлийн сан”** гэдэг ийм сан үүсгээд энэ бүх зээлтэй холбоотой бүх мэдээллийг аваад ингээд тайланг нь бичээд явна. Хэрвээ энэ тайлагнал өөрөө олон улсын түвшинд хүрэх юм бол олон улсаас ч мөнгө орж ирэх боломжтой. Ялангуяа тэр нөгөө CO2 буюу хүлэмжийн хий худалдан авах гэж байгаа.

Тэгэхээр Монгол Улс өөрөө хэрвээ энэ ногоон зээл гаргаад яах юм бол үүнийг худалдаж авъя гээд мөнгө орж ирэх ч боломж нь гарах юм.

Тэгэхээр энэ утгаараа одоо бид хэд энэ өгөгдлийн санг үүсгээд тайлан бүртгэлийг нь ингээд хийхээр 2024 оныхоо төлөвлөгөөнд тусгачихсан. Тэгэхдээ одоо бэлтгэл ажлыг нь хангаад явж байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө ингээд хэвийн болоод явна.

Тэгэхээр ногоон зээл гэж ер нь юуг тодорхойлж, яаж олоод байгаа юм гэхээр ямар ч байсан хуучин ашиглаж байсан усаа цэвэр гүний ус биш саарал ус ашиглаад явах юм бол тэр хэмжээгээр усны хэмнэлт гарна. Үүнийг бас ногоон зээл гэж үзэж байгаа юм.

Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц байгаа юм. Дулаан цахилгаанаа байгалийн нөгөө сэргээгдэх эрчим хүчээр гаргаад явах юм бол энэ орон сууцад олгож байгаа зээл өөрөө ногоон зээл болоод бүртгэхээр.

Тэгэхээр энэ бүх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг нэг стандарт болгож бүртгээд явахыг энэ ногоон зээлийн гэж, бүртгэлийн ажиллагаа гэж хэлж байгаа юм.

Ханшны хувьд яах вэ, энэ оны эхнээс хойш төгрөг ерөнхийдөө тийм их сулраагүй. Нэг хувь хүрэхгүйгээр 0.7 хувийн сулралттай явж байгаа учраас энэ 2023 ондоо төгрөг маш тогтвортой байгаа.

2022 онд 20 гаруй хувиар суларсан. 2023 онд нэлээн тогтворжсон. Дээр нь Монгол Улсын валютын нөөц 4.1 тэрбум доллар болсон байна. Ингээд ч цаашаа нэмэгдэх боломжтой. Ялангуяа нүүрс сайн гараад манай экспорт нэмэгдээд байх юм бол.

Өөр нэг зүйл бол, ялангуяа 2023 онд гарч байгаа нэг зүйл бол импорт ерөнхийдөө оны эхнээс хойш тийм өндөр өсөлт байхгүй байгаад байгаа.

Өнгөрсөн онуудад дандаа 20, 30 хувиар өсөж байсан бол энэ онд өсөлт нь саарсан. Тэр нь мэдээж бас нэлээн сайн дохио. Тэр утгаараа энэ асуудал нэлээн ханш тогтвортой байхаар, нөөц улам нэмэгдээд явахад боломжтой байгаа.

Зүгээр яах вэ, ханш дээр нийлүүлэлтийн гэдгээрээ юу яаж байгаа гэхээр экспортоор орлого олж байгаа аж ахуйн нэгжүүдтэй Монголбанк нэлээн ойрхон ажиллаад, экспортын орлогыг нь аваад тэгээд зах зээл рүүгээ өөрөөрөө дамжуулж нөгөө нийлүүлэлтийн сүлжээ маягаар цахим талбараараа цаашаа валютаа нийлүүлэлт хийх маягаар зохион байгуулах гэж байгаа юм. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: Нэг тодруулаад асуучихъя.

Та нар нэг стандарт гаргаад ирэхээр зэрэг тэр хэн баталгаажуулах юм. Тэр ногоон зээл гарсан байна уу, гараагүй байна гэдгийг чинь дүгнэлт хийж үнэлгээ хийж баталгаажуулах тусгай байгууллага гаднаас байх юм уу, хэн баталгаажуулах юм?

Монголбанк эсвэл баталгаажуулах гээд байгаа юм уу, эсвэл тэр нэг стандарт гаргаж өгчхөөд тэгээд Монголбанк өөрөө хяналт тавих юм уу, эсвэл гуравдагч этгээд хяналт тавих юм уу? Нэг ийм асуулт байна.

Энэ дээр түргэн шуурхай ажил хийхгүй бол ороод ирсэн эх үүсвэрээ ашиглаж чадахгүй байж байгаа юм шиг байна лээ шүү. Бас ийм мэдээлэл ирээд байгаа.

Тийм учраас та бүхэн энэ дээр жоохон шуурхай ажиллах хэрэгтэй байх.

Хоёрт, саяын яг тэр нийлүүлэлтийн сүлжээн дээр яг нэг жишээ хэлээдхээч. Жишээлбэл, ийм компани, ийм орлоготой, ийм экспортлогч, ийм компанийн жишээлбэл ийм орлогыг, жишээлбэл ийм бүтээгдэхүүн гаргаж экспортолж байгаа компанийг бид ингэж энэ нийлүүлэлтийн сүлжээн дээр нь санхүүжилтийг нь одоо тэр зээлийн тусгай гаргаж өгөх гээд байгаа юм байна шүү дээ. Тийм үү? Тэр санхүүжилтийг Монголбанк хийж өгнө гээд байна шүү дээ.

Б.Лхагвасүрэн: Ногоон зээлийн хувьд яах вэ ер нь олон улсын жишиг нь тийм. Бие даасан хөндлөнгийн компани сертификат өгөөд баталгаажуулаад явдаг юм билээ.

Яг өнөөдөр Монгол Улсад яг тийм компани байхгүй. Тэгэхдээ бидний хувьд энэ аудитын байгууллагууд буюу санхүүгийн тайлагнал хийдэг аудитын

байгууллагатай уулзахад тийм боломж байгаа гэсэн.

Тэгэхээр тэр утгаараа тэдгээр байгууллагууд хөндлөнгөөс орж ирэх боломжтой. Эхний ээлжид Монголбанк өөрөө манай Монголбанкны хянан шалгагч өөрөө хүлээж аваад өөрөө тайланг нь баталгаажуулаад эхний ээлжид явах гэж байгаа юм.

Дараа нь мэдээж олон улсын жишигт нийцүүлээд хөндлөнгийн байгууллагаар үнэлээд явна гэсэн ийм бодолтой байгаа юм.

Нийлүүлэлтийн сүлжээний хувьд яах вэ өнгөрсөн жил бидний хувьд ноолуур дээр туршсан юм. Ноолуур бол одоо ингээд анх түүхий ноолуураасаа авхуулаад, хураагдаад, дараа нь угаагдаад самнагдаад, ээрээд, тэгээд сүлжээд эцсийн бүтээгдэхүүн болж байгаа. Энэ шат дамжлага болгоных нь ямар хэмжээний санхүүжилт шаарддаг юм. Тэгээд үнэ өртөг нь.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээгээд хариулчихъя. 3 номер гүйцээгээд хариулчих.

Б.Лхагвасүрэн: Тэгээд яаж нэмүү өртөг үүсэж явдаг юм бэ гэдгийг нь ингээд судлаад нийлүүлэлтийн сүлжээний бүр ийм ноолуур дээрээ зураглал хийчихсэн юм.

Тэгээд энэ зураглалаа Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Олон улсын санхүүгийн корпорац, Азийн хөгжлийн банк гээд гадаадын санхүүгийн байгууллагад танилцуулсан.

Тэгэхээр тэдгээр байгууллагууд яг ийм нарийн судалгаа, тооцоог үзээд нэлээн сонирхож орж ирж байгаа. Ялангуяа тэр Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк нь би нөгөө түрүүчийн

300 сая гээд доллар хэлж байгаа юм. Тэр дотроо нэлээн энэ рүү оруулахаар ингээд яриад аж ахуйн нэгжүүдтэй нь шууд яриад явж байгаа юм билээ.

Яах вэ, Төв банкны зүгээс яаж дэмжих вэ гэхлээр бидний хувьд нөгөө репо санхүүжилт гэж байгаа.

Тэгэхээр үнэхээр тэр бизнес нь өөрөө яваад эхлэх юм бол заавал арилжааны банкны нөгөө хатуу шалгуур, барьцаа хөрөнгө ч гэдэг юм уу, тэр олон шаардлага байхгүйгээр Төв банкны репо санхүүжилтээр энэ нийлүүлэлтийн сүлжээг гацахгүйгээр ажиллуулах ийм боломж байна л гэж харж байгаа юм. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: Хариулт болж байна.

Тэгээд энэ дээрээ Та бүхэнд бас нэг шуурхай ажиллаад, энэ талаараа Байнгын хороог, бас гишүүдийг мэдээллээр хангаж байвал зүгээр байна шүү. Ер нь явц ажлынхаа явцыг Та бүхэнд танилцуулж байгаарай.

Ингээд гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Төсөлтэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Гишүүд үг хэлж дууслаа. Ингээд санал хураалт явуулж эхэлье.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Байнгын хорооны гишүүдийн 53.8 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. /алх цохив/

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулна.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Монголбанкны ажлын хэсэгт баярлалаа. Та бүхэн явж болно.

Хуралдаан 2 цаг 02 минут үргэлжилж, 12 цаг 20 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД